

**Улаанбаатарт: ӨНӨӨДӨР**

Өдөр -10  
Шөнө -19

**УЛС ТӨР**

МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛД ХҮРЭХ ЗАМЫГ ХЭЛЭЛЦЛЭЭ

II нүүрт

**ОНЦЛОХ ХУУДАС**

НЭР СОЛИГДООД ЮУ ӨӨРЧЛӨГДӨХ ВЭ

V нүүрт

Дугаарын **60** мөр  
Цас хайлуулах давс, бодисоо нөөцөл  
Н.БАТЗАЯА

ҮЗЭЛ БОДОЛ

## ХҮЛЭЭЛТ, НАЙДЛАГА ДАГУУЛСАН АН-ЫН ИХ ХУРАЛ



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Улаанбаатарчуудыг 14 хоног түргэн авахуулж сандаргасан цас арилж, нэг юм амьсгаа авахтайгаа болов. Хэд хоногийн турш цасанд дарагдаж, гөлийтөл хөлдсөн замын хальтиргаа гулгаа ч эхнээсээ арилж, нарлаг сайхан өдрүүд үргэлжилж байна. Гэхдээ энэ өдрүүд удаан үргэлжлэхгүй гэдгийг холбогдох албаныхан анхааруулаад буй. Тодруулаад хэлбэл, ирэх сарын цаг агаарын урьдчилсан мэдээгээр агаарын дундаж температур нийт нутгийн хойд хагас болон Алтайн цаад нутгаар олон жилийн дунджаас хүйтэн, бусад нутгаар дунджийн орчим, хур тунадас ихэнх нутгаар олон жилийн дунджийн орчим ба түүнээс ахиу орно гэдгийг анхааруулж, удаа дараа хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан мэдээлсэн.

Үргэлжлэл нь III нүүрт

Б.ӨНӨРТОГТОХ

Лам олдохгүй бол буцахдаа

залахын үлгэрээр Ардчилсан намын фракциудын эцэс төгсгөлгүй улстөржилт, талцал хуваагд-

лаас залхсан ард түмэн МАН-ын 65 гишүүнд төр удирдах эрхийг атгуулж, үнэмлэхүй олонхийн

суудал өгсөн нь саяхных. Гэвч энэ сонголт зөв байсан уу гэдэгт эргэлзэх хүмүүс бишгүй олон болс-

ныг сарын өмнө болсон орон нутгийн сонгуулийн дүн харуулсан. Үргэлжлэл нь III нүүрт

ОНЦЛОХ МЭДЭЭ

### Оюутны сургалтын зээлийг энэ долоо хоногоос олгоно

Н.БАТЗАЯА

Оюутнууд сургалтын төлбөрөө зээлээр авах боломж бүрдсэн билээ. Тэгвэл энэхүү зээлийг арилжааны банкуудаар энэ долоо хоногоос олгож эхлэхээр болжээ. Энэ талаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ж.Батсуурь “Сургалтын зээл олгоход шаардагдах бэлтгэл ажлыг дуусгасан. Оюутнуудад сургалтын төлбөрийн зээл олгох бэлтгэл ажил дуусч, бэлэн болсон” гэж мэдээллээ. Сайд Ж.Батсуурийн

мэдээлснээр 2016-2017 оны хичээлийн жилд сургалтын төлбөрөө төлөх боломжгүй 74 мянган оюутан байна. Мөн хоёр болон түүнээс дээш хүүхэд нь зэрэг суралцаж буй өрхийн нэг хүүхдэд олгох сургалтын төлбөрийн буцалтгүй тусламжийг 1500 орчим оюутанд олгох тооцоо гаргажээ. Улсын хэмжээнд 164 мянган оюутан төрийн болон төрийн бус өмчийн их, дээд сургуульд суралцаагийн 125 мянга нь бакалаврын өдрийн ангид сурдаг гэх тооцоо гаргажээ.

ДОТОР НҮҮРТ



КУБЫН ХУВЬСГАЛЫН ЭЦЭГ ТААЛАЛ ТӨГСЛӨӨ

6

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

### Ж.АМГАЛАН: АЛИВАА ЗҮЙЛД СУДАЛГААТАЙ, УЛ СУУРЬТАЙ ХАНДАЖ СЭТГЭХГҮЙ БОЛ БИД ДЭЛХИЙГЭЭС ХОЦРОХ ГЭЭД БАЙНА

Х.НОРЖИН

Төрийн удирдлага-үндэсний аюулгүй байдлын стратегийн судлаач, Ж.Амгалантай ярилцлаа.

-Манай улсад судалгааны тэр тусмаа аюулгүй байдлын судалгааны байгууллагуудын

үйл ажиллагааг олон улсын ийм чиглэлийн байгууллагуудтай харьцуулан үзэхэд ямар төвшинд явна вэ?

-Аливаа улсын аюулгүй хөгжих, эрсдлийг урьдчилан тооцож даван туулах чадвар бодлогын судалгааны байгууллагуудаас нэлээд хамаардаг. Судалгааны байгууллагуудын судалгааны чиглэл, хамрах хүрээ, чанар, судлаачдын ур чадвар, ажлын

үр дүн ямар байна тийм л төвшинд тухайн улсын судалгааны бодлого явна. Гол нь мэргэжилтэнээ бэлтгэх, тэр бэлтгэгдсэн мэргэжилтний мэдлэгийн төвшин, ёс суртахуун, асуудлын талбайг хэрхэн эзлэхээс их зүйл шалтгаална. Нөгөө талаас судалгааны сайн ажлыг үр дүнтэй ашиглаж чадахгүй бол үр дүн гарахгүй.

Үргэлжлэл нь IV нүүрт



БИД ТАНЫ АЖЛЫГ ХҮНДЭЛНЭ



Алдаж болохгүй алтан боломж

Dell-ийн Inspiron, Vostro загварын компьютер худалдан аваад 25.000₮-ийн ваучер бэлгэнд аваарай.



ХААН банк

	Авах	Зарах	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2450.00	2464.00	ФУНТ	2993.00
ЕВРО	2548.00	2617.00	РУБЛЬ	36.60
ИЕН	21.55	22.06	ЮАНЬ	351.00

Хугалгаа хөгжлийн банк

	Авах	Зарах	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2455.00	2469.00	ФУНТ	3003.00
ЕВРО	2549.00	2681.00	РУБЛЬ	35.94
ИЕН	21.33	22.46	ЮАНЬ	353.00

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

# УЛС ТӨР

## МЭДЭЭЛЭЛ

### Намын бүлэг, ажлын хэсэг хуралдана

Монгол Улсын Их Хурлын 2016 оны намын ээлжит чуулганы арваннэгдүгээр сарын 28-аас арванхоёрдугаар сарын 02-ны өдрүүдэд намын бүлэг, ажлын хэсэг, байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал, хуваарийг танилцуулж байна. Тодруулбал, өнөөдөр УИХ дахь Монгол Ардын намын бүлгийн хуралдаан “Жанжин Д.Сүхбаатар” танхимд хуралдах бол Ардчилсан намын бүлэг “Их эзэн Чингис хаан” танхимд хуралдана.

Үүнээс гадна энэ өдөр Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Хууль зүйн байнгын хорооны ажлын дэд хэсгийн хуралдаан 09.30 цагаас 334 тоот өрөөнд хуралдана. Мөн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Хууль зүйн байнгын хорооны ажлын хэсгийн хуралдаан 14.00 цагаас 334 тоот өрөөнд хуралдана.

## ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

# Монгол Улсын ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛД ХҮРЭХ ЗАМЫГ хэлэлцлээ



### Э.ТУУЛ

“Тогтвортой хөгжил 2030: Төлөвлөлтөөс хэрэгжилтэд үндэсний чуулган болж, өнгөрлөө. Чуулганы хүрээнд “Монгол Улсын тогтвортой хөгжилд хүрэх зам” дээд төвшний уулзалт Төрийн ордонд болсон бөгөөд УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо, Ерөнхий сайдын ажлын алба, БОАЖЯ, Сангийн яам болон түнш байгууллагууд хамтран зохион байгуулсан юм. Уулзалтад Ерөнхий сайд илгээлт ирүүлж, УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны дарга Д.Тэрбишдагва, БОАЖ-ын сайд Д.Оюунхорол, Сангийн дэд сайд Х.Булгантуяа, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Суурин төлөөлөгч хагатай Беате Транкманн, Ногоон

...Монгол Улс 2030 он гэхэд эдийн засгийн жилийн дундаж өсөлт тогтвортой 6.6 хувиас доошгүй байж, нэг хүнд ногдох үндэсний нийт орлого 17 500 ам долларт хүрч, ядуурлын бүр төрлийг эцэс болгон, Монгол хүний эрүүл, урт удаан амьдрах нөхцөл хангагдаж, дундаж наслалт 78-д хүрч, хүний хөгжлийн өндөр үзүүлэлт бүхий дэлхийн эхний 70 орны нэг болж, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалсан, ногоон эдийн засгийн үзүүлэлтээр дэлхийн эхний 30 оронд багтсан орон болох юм...

эдийн засгийн төлөөх түншлэлийн Ногоон эдийн засгийн асуудал хариуцсан дарга Асад Наки нар нээж, үг хэлэв. Энэ удаагийн дээд хэмжээний уулзалтын зорилго нь Монгол Улсын хөгжлийн бодлогын уялдаа холбоо, салбар дундын нэгдсэн зохицуулалт, төлөвлөлт, удирдлага, санхүүгийн тогтолцоо, хөрөнгө оруулалт зэрэг асуудлыг хэлэлцэж, олон талт хамтын ажиллагааг өргөжүүлж, санхүүжилтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн. БОАЖ-ын сайд Д.Оюунхорол “Монгол Улс байгалийн унаган төрхөө хадгалж үлдсэн, олон мянган жилийн тэртээгээс байгальтайгаа зохицон амьдарч ирсэн, дахин давтагдашгүй нүүдлийн соёл иргэншилтэй, эрчимтэй хөгжиж байгаа цөөн орны нэг” хэмээн нээлтийн эхэнд онцлохын зэрэгцээ “Уур амьсгалын өөрчлөлт эдийн засаг, хүн амын хурдацтай өсөлт, байгаль орчны бохирдол, доройтол нь өнөө үед экосистемийн тэнцвэрт байдал алдагдахад хүргэж, улс орнуудын тогтвортой хөгжилд сорилт болж байна. Монгол Улсын хувьд уур амьсгалын өөрчлөлт дэлхийн дунджаас хэд дахин хүчтэй явагдаж байна. Тухайлбал, сүүлийн 70 гаруй жилийн хугацаанд агаарын дундаж температур 2.1 хэмээр дулаарсан нь дэлхийн дунджаас гурав дахин их байгаа юм. Үүний улмаас гол ус хатаж ширгэх, мөнх цөвдөг хайлах, бэлчээрийн доройтол, цаг агаарын аюулт үзэгдлийн давтамж, хамрах хүрээ нэмэгдэж байна. Түүнчлэн, хотжилтын нөлөөгөөр агаар, хөрсний бохирдол гамшгийн

хэмжээнд хүрсэн. Улаанбаатар хотод сүүлийн 10 жилийн байдлаар хүн амын амьсгалын замын эрхтний өвчлөл 2.4 дахин нэмэгдсэн. Тиймээс манай орны төдийгүй дэлхий нийтийн өмнө тулгамдаж байгаа эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд улс орнууд тогтвортой хөгжлийг хангах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах чиглэлээр идэвхитэй хамтран ажиллаж, байгальд ээлтэй хөгжлийн загвар бий болгохыг эрмэлзэж байна. Бидэнд тулгараад байгаа өнөөгийн эдийн засгийн хүндрэлийг даван туулахад эдийн засгаа төрөлжүүлэн хөгжүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх, тэргүүлэх салбаруудыг байгальд ээлтэй “ногоон” болгох зайлшгүй шаардлага тулгарч байна” хэмээн онцлон хэлэв.

НҮБ-ын Ногоон эдийн засгийн төлөөх түншлэлийн Нарийн бичгийн дарга нарын газрын тэргүүн Асад Накви “Монгол Улс нь ногоон эдийн засгийн төлөөх түншлэлийг амжилттай хэрэгжүүлж, бусад оронд дуурайлал болж буй орон юм” хэмээн үнэллээ. Мөн Д.Оюунхорол сайд Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн хүрээнд байгаль орчин, ногоон хөгжлийн бодлого, хууль тогтоомжийг боловсруулж, батлуулахын зэрэгцээ бодитой үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байгаа талаараа танилцуулав. Тухайлбал, ногоон барилгын үндсийг тавьж, сургууль, цэцэрлэгийн жишиг ногоон барилгын зураг төсөл боловсруулж байгуулах, ногоон үйлдвэрлэл, аж ахуй эрхлэлтийг дэмжих ногоон зээлийн сан, эко урамшуулал зэрэг эдийн засгийн хөшүүргүүд бий болгох зэрэг багагүй ажлыг эхлүүлсэнээ дурдаж, “Монгол Улсын тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн ногоон хөгжил, ногоон эдийн засгийн

төлөөх түншлэлийн уриалга”-ыг санаачилжээ. Түүнчлэн Монгол Улс хүртээмжтэй ногоон эдийн засагт шилжих хөдөлгөөний явцад гарсан чухал амжилт нь УИХ-аас 2014 онд Ногоон хөгжлийн бодлогыг баталсан явдал юм. Өнгөрсөн оны нэгдүгээр сард Засгийн газраас уг бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан. Уг төлөвлөгөөнд 225 үйл ажиллагааг 2030 он хүртэл хэрэгжүүлэхээр тусгасан билээ. Мөн өнгөрсөн оны хоёрдугаар сард УИХ-аас Тогтвортой хөгжлийн 2030 хөгжлийн үзэл санаанд суурилсан, өөрийн орны онцлог нөхцөл, тэргүүлэх чиглэл, тулгамдаж буй асуудлуудыг нягт уялдуулсан Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг баталсан. Уг үзэл баримтлалд Монгол Улс 2030 онд нэг хүнд ногдох орлогоороо дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээд хүрсэн, тогтвортой өсч байгаа эдийн засгийн олон салбартай, нийгмийн хүрээнд дундаж болон чинээлэг дундаж давхрага давамгайлсан, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалсан, ардчилсан засаглалтай улс болно гэсэн зорилгыг дөвшүүлж 14 чиглэлээр хэрэгжүүлэх 44 зорилгыг тодорхойлсон юм. Эдгээр зорилгод хүрч чадсанаар Монгол Улс 2030 он гэхэд эдийн засгийн жилийн дундаж өсөлт тогтвортой 6.6 хувиас доошгүй байж, нэг хүнд ногдох үндэсний нийт орлого 17 500 ам долларт хүрч, ядуурлын бүр төрлийг эцэс болгон, Монгол хүний эрүүл, урт удаан амьдрах нөхцөл хангагдаж, дундаж наслалт 78-д хүрч, хүний хөгжлийн өндөр үзүүлэлт бүхий дэлхийн эхний 70 орны нэг болж, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалсан, ногоон эдийн засгийн үзүүлэлтээр дэлхийн эхний 30 оронд багтсан орон болох юм.

БОАЖЯ-ны зүгээс Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн хүрээнд байгаль орчин, ногоон хөгжлийн бодлого, хууль тогтоомжийг боловсруулж батлуулахын зэрэгцээ бодит үйл ажиллагаануудыг хэрэгжүүлж байна. Тухайлбал, ногоон барилгын үндсийг тавьж, сургууль цэцэрлэгийн жишиг ногоон барилгын зураг төсөл боловсруулж байгуулах, тогтвортой санхүүжилтийн хөтөлбөрийг дэмжиж, ногоон зээлийн сан, эко урамшуулал, хүлэмжийн хийг бууруулахад чиглэсэн төслийн санал боловсруулж Уур амьсгалын ногоон санд хандах ажлыг бусад яамд аментлагтай хамтран хийж байна. Хамгийн сүүлд л гэхэд Японы Засгийн газартай Хамтсарсан кредит олгох механизмын хүрээнд хэрэгжүүлсэн төслөөс анхны нүүрстөрөгчийн кредитийг аваад байна. Өнөөдөр эдийн засгийн асалт буурч, гадаад дотоодын хөрөнгө оруулалт багассан байгаа хэдий ч үндэсний урт хугацааны бодлого, Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоосоо ухралгүй төр хувийн хэвшил, олон улсын байгууллагын хамтын ажиллагааг идэвхижүүлж, санхүүжилтийг нэмэгдүүлснээр өмнөө тавьсан зорилтдоо хүрнэ хэмээн зохион байгуулагчид онцоллоо. Үндэсний чуулганы хүрээнд “Тогтвортой хөгжлийн бодлого, үйл ажиллагаа, инновац”, “Санхүүгийн системийг хөгжлийн бодлоготой уялдуулах нь” салбар хуралдаанууд, “Хөгжлийн шийдэл, хамтын ажиллагаа, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаа” зэрэг сэдвүүдээр хэлэлцүүлэг өрнүүлжээ. Дээд хэмжээний уулзалтад төр хувийн хэвшил болон орон нутгийн Засаг дарга нар, олон улсын байгууллагын 160 гаруй төлөөлөгчид оролцсон юм.

**МММINFO**

**МОНГОЛЫН МЭДЭЭ**

18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: **С.ГАНТОГОО**

Орлогч эрхлэгч: **Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158**

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: **Э.ЭНХЦЭЦЭГ 90873012**

Ахлах редактор: **Б.ӨНӨРТОГТОХ 88006842**

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: **Н.ПУНЦАГБОЛД 88096454**

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: **Б.ӨНӨРТОГТОХ 88006842**

Гэрэл зургийн алба: **Г.АРГУУЖИН 96017873**

Компьютерийн алба: **Б.ГАНЗОРИГ 99998796**

Маркетинг, зар сурталчлалгааны алба: **Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710**

Захиалга, борлуулалтын алба: **М.ДАВААДУЛАМ 99042510**

**Э.САЙНЗАЯА 99197866**

Дугаарыг эрхэлсэн **Н.ПУНЦАГБОЛД**

Улсын бүртгэлийн дугаар: 907300528  
Индекс: 100757

Редакцийн хаяг: **Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот**

Харилцах утас, факс: **976-70113551**

“Монголын мэдээ” сонины редакцт эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

## МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

### Уул уурхайн дэд сайд хэн болох вэ

Уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэрийн ерөнхий захирлаар Х.Бадамсүрэн-томилсон. Тэрбээр энэ албанд томилогдохоос өмнө Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайдаар ажиллаж байсан юм. Тэгвэл Х.Бадамсүрэнгийн оронд хэн томилогдох вэ гэсэн дэд сайдын марафон эхэлчихэж, МАН дотор. Дарга болох сонирхолтой олон хүн энэ марафонд оролцож байгаа гэх. Гэвч Засгийн газраас мэргэжлийн, туршлагатай хүн томилох шаардлагатай гэсэн байр суурь баримталж буй.

Одоогоор дэд сайдад УИХ-ын гишүүн асан Д.Загджав, Д.Зоригт, Т.Бадамжунай нар марафонд тэргүүлж яваа гэнэ. Эрчим хүчний сайд асан Д.Зоригтын нэр яригдаж байсан ч тэрээр өөрөө “Би дэд сайдын албан тушаалд очихгүй. Миний талаар ийм зохион байгуулалттай мэдээлэл тараагаад байгаад гайхаж байна” гэсэн тайлбарийг өгсөн. Харин Д.Загджав, Т.Бадамжунай нарын хувьд одоогоор дэд сайдын суудалд суухгүй гэсэн тайлбар өгөөгүй байгаа юм. Т.Бадамжунай хувьд өмнө нь

Хүнс, хөдөө аж ахуйн сайд байсан МАН дотроо нэр хүнд сайтай туршлагатай, намын даргатай хамгийн ойр байдаг улстөрчийн нэг. Д.Загджав УИХ-ын гишүүн байснаас хойш томоохон алба тушаал хашиж байгаагүй ч нам дотроо шүүмжлэл хэлчихдэг залуучуудын нэг гэж дүгнэх хүмүүс бий. Тэгэхээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дэд сайдад нэр дэвших магадлал өндөртэй Д.Загджав, Т.Бадамжунай хоёрын хооронд “тулаан” үргэлжлэх болов уу.

### АН-ын Үүрийн дарга нарын холбоо шаардлага хүргүүлжээ

Ардчилсан намын Үүрийн дарга нарын холбооноос “АН-ын үүрийн гишүүд, дэмжигчдийн I хэлэлцүүлэг”-ийг зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт Улаанбаатар хотын АН-ын 150 гаруй үүрийн төлөөлөл болох 113 үүрийн дарга, идэвхтэн төлөөлөгч нар маш идэвхтэй, чөлөөтэй оролцсон байна. Хэлэлцүүлэгт ирсэн төлөөлөгчдийн дийлэнх олонх нь намын шинэчлэл нь цөөн хэдхэн дарга нар, фракцийн толгойлогчдын тохиролцооны хүрээнд явагдах ёсгүй гэж үзсэн байна. Иймээс тус холбооны зүгээс АН-ын их хурлыг зохион байгуулах ажлын хэсэгт шаардлага

хүргүүлсэн байна. Шаардлагад 2016 оны арванхоёрдугаар сарын 06-ны өдөр болох Ардчилсан намын VI их хуралд намын анхан шатны үүр бүрээс нэг төлөөлөгч байгаа нь хэтэрхий бага тул нэмж өдөр тутам намын үйл ажиллагааг нуруун дээрээ үүрч явдаг үүрийн дарга, улс төрийн ажилтнуудыг шууд оролцох боломжоор хангах, АН-ын даргын сонгуулийн үйл ажиллагааг сунтаагаар бүх шатны гишүүдийн оролцоотойгоор сонгох нь анхан шатныхаа оролцоог хангасан намын суурь шинэчлэлийн нэг болж чадна, Намын их хурлыг олон нийтийн мэдээллийн хэрэгсэлээр


шууд дамжуулж ардчилсан намын нийт 160 мянга гаруй гишүүд болон олон нийтэд нээлттэй харуулах зэрэг шаардлагыг хүргүүлжээ. Эдгээр шаардлагуудыг хүлээн авч шийдвэрлэхгүй бол Ардчилсан намын Үүрийн дарга нарын холбооноос дараагийн арга хэмжээнүүдийг авч тэмцлийн хүрц хэлбэрийг сонгон Их хурлыг хуралдуулах ҮЗХ-ны шийдвэрийг зогсоох, хүчингүй болгох хүртэл дараалсан арга хэмжээнүүдийг авах болно гэдгээ үүгээр хатуу мэдэгдэж байна гэсэн шаардлага АН-ын дүрмийн төслийг боловсруулах ажлын хэсгийн гишүүдэд хүргүүлжээ.

**“Эрдэнэт”-ийг удирдах хүмүүс тодорлоо**

Уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэрийн Төлөөлөн удирдах зөвлөл өнгөрсөн баасан гарагт хуралдаж, “Эрдэнэт” үйлдвэрийн ерөнхий захирлаар Х.Бадамсүрэн, ТУЗ-ын дарга У.Бямбасүрэн нарыг томилох шийдвэрийг гаргасан юм. “Эрдэнэт” үйлдвэрийн Ерөнхий захирал Х.Бадамсүрэнгийн тухайд тэрбээр Уул уурхайн инженер-маркшейдер мэргэжилтэй. Техникийн шинжлэх ухааны доктор зэрэгтэй. Төрийн албанд 32 жил ажилласан туршлагатай хүн юм. Тус үйлдвэрийн 51 хувийг Монголын Засгийн газар, 49 хувийг “Монголын зэс компани” эзэмшдэг. Тиймээс “Эрдэнэт”-ийн ТУЗ-ийн долоон хүний дөрвийг нь Засгийн газраас гурвыг нь “Монгол зэс” компаниас томилсон. Тодруулбал, “Эрдэнэт”-ийн ТУЗ-д У.Бямбасүрэн, Д.Дэмбэрэл, Г.Нандинжаргал, Н.Доржсэмбэд нар Засгийн газрыг төлөөлөх бол “Монгол зэс”-ээс Да.Ганболд, О.Орхон, М.Мөнхбаатар нар ТУЗ-ийн гишүүдээр томилогдлоо. Дашрамд дурьдахад, “Эрдэнэт” үйлдвэрийн ерөнхий захирлаар ажиллаж байсан Ц.Даваацэрэн гурван жил гаруй “Эрдэнэт”-ийг удирдаад ийнхүү ажлаа өглөө.

# ҮЗЭЛ БОДОЛ

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ



Гэрлэ зургийг Г.АРГУУЖИН

### Дугаарын 60 мөр Цас хайлуулах давс, бодисоо нөөцөл

Үргэлжлэл.  
Түрүүч нь I нүүрт

Тэр дундаа 100 жилд байгаагүй их хэмжээний цас орно хэмээн анхааруулсан гэдгийг энд онцолъё. Ингэж анхааруулаад байхад нар гийсэн налгар өдрүүд үргэлжлэх нь гээд налайгаад суув даа, Засаг дарга аа. Өнгөрсөн үлгэрийн далайгаа дахин давтав. Хотын дарга нь долоо хоногт хэдэн удаа цас орсныг тоолж, аргаа барсанддаа өөрөө хүртэл хүрэээ бариад цасаа цэвэрлэж зогссон. Энэ үеэр их хэмжээний цас орсонтой холбогдуулан Хот тохижилтын газраас “Бид шуурхай арга хэмжээ авч ажиллаж байна. Аравдугаар сарын 24-нд 56 тн бодис, энэ сарын 5-нд хот тохижилтын 200 гаруй ажилчин 38 тонн цас хайлуулах бодис, энэ сарын 17-нд Нийслэлийн 337 км замуудад цас хайлуулах бодис цацсан” хэмээн мэдээлж байв. Гэсэн ч үг, үйлдэл хоёр нь бодит байдалтай зөрчилдсөн. Нөгөө их цацсанаа гайхуулаад байсан 200-300 тонн бодисных нь ч нэмэр байсангүй. ГССҮТ-ийг зорих иргэдийн тоо олширч, өдөрт 100-150 хүн тус хүлээн авахад хандах болсон. Тэгэхдээ тус төвд хандаж байгаа хүмүүсийн дийлэнх нь халтирч унаад хөл, гараа хугалсан иргэд байгаа талаар эмч мэргэжилтнүүд ч хэлж байв. Нийслэлийн шинэ удирдлагуудын үлгэр үүгээр ч дуусаагүй. Хотын ерөнхий менежер Т.Гантөмөр “25 суваг” телевизийн мэдээллийн хөтөлбөрт орохдоо “Төрийн ордон тойрсон буюу дарга нарын явдаг замуудад элс, давс цацаад, захын хороололын замуудад огт цацахгүй байна гэх шүүмжлэлийг иргэд маш их хэлж байна” хэмээн сэтгүүлчийн тодруулсан асуултад “Хаагуур цацахаа бид мэдье” хэмээн том дугарч олны дургүйцлийг хүргээд зогсохгүй, хүүхэд нохойн доог болох шахсан. Үнэндээ бүхэл бүтэн нэг сая 500 гаруй мянган хүн амтай хотыг хариуцсан дарга ийм зүйл яриад сууна гэдэг эмгэнэл. Ямар сайндаа л аргаа барсан замын цагдаа нар дэлгүүрээс давс худалдан авч, гараараа цацаж явах вэ дээ. Мега хотын хэмжээгээс давсан том хотын хувьд цасандаа дарлуулаад сууна гэдэг үнэндээ ичмээр. Хамгийн сүүлд Нийслэлийн захирагчийн албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсээс энэ сарын 24-нд ОХУ-аас 198 тонн тусгай зориулалтын бодисыг 110 гаруй сая төгрөгөөр худалдаж авч байгаа талаар мэдээлсэн. Мөн Засаг даргын нөөц хөрөнгөөс дахин 400 тонн бодис авахаас гадна БНХАУ-аас явган хүний замна цас мөс шүүрдэх, замд хөлдсөн цасыг ховхлож техникүүд авахаар захиалсан тухай НЗДТГ-ын Хэвлэл мэдээллийн албанаас мэдээлээд буй. Тэгвэл энэ захиалсан техник хэрэгсэл, давс хайлуулах бодисоо эртхэн шиг нөөцлөөд авахгүй бол ирэх сард 13-аас илүү цас орох нь байна шүү, Засаг дарга минь. Цаг тайван, хугацаа байгаа дээр нь хэдэн техник, хэрэгсэл бэлдчихээд сэтгэл амар суухад яах вэ дээ. Бүр болохгүй бол дотооддоо бага хэмжээгээр цас хайлуулах бодис үйлдвэрлэх боломжтой талаар хэсэг эрдэмтэд хэлээд буй. Тэднийгээ дэмжээд ОХУ-руу захиалах бодисныхоо тодорхой хувийг эх орондоо үйлдвэрлэхэд буруудахгүй л болов уу. Ядаж л цаг хугацаа хэмнэнэ. Арванхоёрдугаар сар гарахад тав хүрэхгүй хоног үлдэж. Тэгэхээр энэ хугацаанд өмнөх алдаанаасаа суралцаад ядаж шаардлагатай бодисоо хангалттай нөөцлөнө биз. Арай дахиад иргэдийнхээ өөдөөс сүүлийн 100 тонн бодисоо цацсан гэх тайлбар хэлэхгүй биз дээ, Засаг дарга минь.

ҮЗЭЛ БОДОЛ

Үргэлжлэл.  
Түрүүч нь I нүүрт

Өөрөөр хэлбэл, Ардын нам нь арай дээр байх болов уу хэмээн сохроор найдаж, МАН-аас дэвшсэн бор халзан хонийг хүртэл дугуйлж орхисон иргэд далаараа цэвэр тавиулж орхисноо хожимдож ухаарсан хэрэг. Алийг нь ч сонгосон

нам нь арай дээр байж дээ гэх үг учир мэдэх хүмүүсийн амнаас унах болжээ. Талхны мөнгө, гудамжны цасанд санаа зовнисон монголчуудыг арай холыг хардаг, томыг төсөөлдөг болгох, эх хүүхдийн 20 мянган төгрөгөөр улс төрхийдэг биш их бүтээн байгуулалт хийж, улсын хөгжил дэвшлийг удирддаг төр байгуулах үүрэг АН-д дахиад



Гэрлэ зургийг Г.АРГУУЖИН

# ХҮЛЭЭЛТ, НАЙДЛАГА ДАГУУЛСАН АН-ЫН ИХ ХУРАЛ

адилхан юм байна хэмээн цөхөрч орхисноо орон нутгийн сонгуулиар илэрхийлж, санал өгөхөөс татгалзан ирд бүрдэхгүйд хүрч байв. Цаашид хэрхэх вэ, 2020 онд хэнд итгэх вэ гэсэн асуулт харилт эрсээр байгааг нуух юун. Ард түмний итгэлийг авсан МАН-ынхан амьдралыг нь өөд татах бус албан тушаалаа хуваарилж, мөнгөгүйн зовлон тоочсоор дөрвөн сарыг үдчихлээ. Ямар ч улсын Засгийн газар, УИХ-ын эхний 100 хоног ирэх дөрвөн жилд хийх их ажлынхаа шанг татдаг, том ажлыг эхлүүлдэг хариуцлагатай цаг үе байх учиртай. Гэтэл МАН-ын Засгийн газар эхний гурван сар зөвхөн нэр солих, “бор халзан” гишүүд нь ах дүүгийн харилцаагаа мартаж төрийн хүн болсон гэдгээ ойлгох “ухаарлын” цаг хугацаа болж өнгөрлөө. Ардчилсан намын эхлүүлсэн Хамтын тэтгэврийг Насны хишиг болгох, “Сайн оюутан”-г өөрчилж оюутны сургалтын зээл болгох, уул усны нэр өөрчлөх, амралтын өдөр хоногийг нааш цааш болгох гэх мэтээр жижигхэн асуудалтай зууралдсаар дөрвөн сарыг үдлээ. Ард түмэн бид ч тэнэг болж гүйцжээ. Атаг чихэр өгөхөөр магнай хагартал байрлаж, аваад хураачихвал тунниж гүйдэж жаахан хүүхэд аятай л хүүхдийн мөнгө өгнө гэхэд нь баярлаж, өгөхгүй гэвэл тунниж гүйсээр өвөлтэй золгов. Ирэх оны төсөвт мөнгө өгөх заалт ороосой хэмээн залбирал нь холгүй л горьдож суудаг боллоо. Ямар юмныхны бүтээн байгуулалт, эх орны хөгжил дэвшил, 20 мянган төгрөгөө хэл амгүйхэн авч, хоногийн хоолоо залгуулж байвал баярладаг мунхаг, харанхуй цаг үе рүүгээ эргээд ухарч байна. 2012 оноос АН-ынхан өр тавиад ч болов үндэсний хэдэн үйлдвэрээ хөл дээр нь босгосны хүчинд өнөөдөр идэх талхгүй, өмсөх хувцасгүй болчихолгүй тэсч байгаа юм. Ардчилсан

ногдох нь дамжиггүй. Тэр их итгэлийг дахин авахын тулд энэ нам өнгөрсөн дөрвөн жилийн алдаанаасаа суралцаж, илүү шинэчлэгдэх учиртай. Иргэд ч үүнийг хүсч буй. Тэр шинэчлэл нь албан тушаал горилсон хэсэг залуус зурагтаар онол ярьж “хэлбэрдэх”, фракцийн дарга нар нь өвөр зуураа хор найруулж намын даргаа солих тухай биш юм. Намын эгэл жирийн гишүүдийг үйл ажиллагаандаа татан оролцуулж, Ардчилсан нам дарга нарын нам биш гэдгийг л багтах тухай асуудал. Даргад таалагдсан нь шийдвэр гаргах төвшинд ажиллаж, жирийн гишүүд нь зөвхөн сонгуулиар санал өгөхөд л хэрэг болдог гэжиг тогтолцооноосоо салахгүй л бол зөвхөн намын даргаа солиод АН шинэчлэгдэхээс өнгөрсөн. Ирэх сарын 06-нд хуралдах намын Их хурал иргэдийн бүх хүлээлтэд харилт өгөх учиртай. Намдаа эрс шинэчлэл хийх үү, эс бөгөөс фракцийн улс төр өрнөж, намын даргыг өөрчилсөн болоод өнгөрөх үү гэдэг нь анхаарал татах сэдэв байх нь мэдээж.

### Их хурлын үндсэн сэдэв намын даргыг солих уу

Ийм таамаг хэдийнэ улс төрийн хүрээнд гарч эхэлжээ. Ойрын өдрүүдэд толгойтой болгон нь АН-ын дарга болох тухай мөрөөдлөө ярьж эхэлснээс хойш Их хурлаараа тэд намын даргаа өөрчлөх нь ээ гэсэн яриа гарахад хүрчээ. Тэгвэл Их хурлын үндсэн сэдэв нь намын үндсэн дүрмийг шинэчлэх асуудал аж. Өөрөөр хэлбэл, ҮЗХ, Хяналтын зөвлөлийг зөвхөн намын дарга, фракцийн даргын ойрын хүмүүсээр бүрдүүлэх боломж олгож байсан хуучин дүрмийг өөрчлөх асуудал энэ үлдэгийн Их хурлын гол сэдэв байх гэнэ. Намын дүрэм гэдэг маш олон зүйлийг тусгасан томоохон бичиг баримт.

Тиймдээ ч өөрчлөлт бүрийг тоочих нь илүүц биз. Их хуралд оролцох төлөөлөгчдийг өмнө нь дарга тодруулдаг байсан бол энэ удаад намын жирийн гишүүд нь хуралдаж тодруулахаар болж, өнгөрсөн амралтын өдрүүдээр аймаг, сум дүүргийн хэсгийн хороодууд хуралдаж төлөөлөгчдөө томилж эхэлжээ. Намын үүрийн дарга нар Их хуралд оролцоно хэмээн дээр дооргүй хэрүүл тэмцэл хийж эхэлсэн ч энэ удаагийн Их хурал дарга нарынх биш жирийн гишүүдийн, намынхаа төлөө яваа олон зуун дэмжигчдийн хурал болох аж. Мөн төлөөлөгчдийн тооны харьцааг тэнцвэржүүлэх үүднээс залуус, эмэгтэйчүүд, ахмадуудын квотыг нэмж өгсөн тухай эх сурвалж дуулгалаа. Орон нутагт АН-аас нэр дэвшч ИХТ-д сонгогдсон төлөөлөгчид Их хуралд оролцох бөгөөд иргэдийн хүсч хүлээж буй шинэчлэл, өөрчлөлтийн талаар байр сууриа илэрхийлэх боломжийг бүрдүүлж өгчээ. Орон нутгаас ирэх эдгээр төлөөлөгчид АН-ын мянга мянган жирийн гишүүд, дэмжигчдийн дуу хоолой болно уу гэхээс даргын өмнөөс дуугардаг “утсан хүүхэддэй” биш байгаагай гэсэн хүлээлт байгааг ч нуугаад яахав. Ардчилсан намын шинэчлэл нь нэг дарга солиод болдог асуудал биш гэдгийг ойлгох, Их хурлаа илүү үр дүнтэй болгож чадах эсэх нь орон нутгаас ирэх эдгээр төлөөлөгчдөөс ихээхэн шалтгаалах учиртай.

### АН даргын бус бодлогын фракцитай болно

Намын дүрэмд орох гол өөрчлөлтөөс онцолвол, АН-ын даргыг ҮЗХ-ны цөөн хэдэн гишүүд биш жирийн гишүүд сонгодог байхаар өөрчлөлт оруулахаар болжээ. Түүнчлэн, аймаг, сум дүүргийн хэсгийн хороодын даргыг ч жирийн гишүүд нь хуралдаж томилох хэмээн шинэ дүрэмд тусгажээ. Ингэснээр фракцийн даргын ойрын хүн аймаг, сум, дүүргийн намын дарга болчихоод намын гишүүдээ манай, танай фракци хэмээн ялгадаг байдал алга болох юм. Дүрмээ шинэчилж баталсны дараа л намын болон аймаг, сум, дүүргийн хэсгийн хороодын дарга нарыг томилох асуудал яригдах сурагтай. Мөн даргын фракци байхгүй болж оронд нь бодлогын фракци, бүлэг бий болох, албан тушаалын төлөө биш улс орны хөгжлийн төлөө үзэл бодлоороо эвлэлдэн нэгддэг болно хэмээн дүрэмд тусгасан байна. АН бол баруун төвийн нам гэдгээ Их хурлаараа баталгаажуулахаас гадна ротацийг хоёр жил тутамд нэг удаа хуралдуулах, ротацид суух төлөөлөгчдийн нас, хүйсийн харьцааг тэнцвэржүүлэх үүднээс эхний 76-г нь УИХ, Засгийн газрын гишүүд болон болон аймаг, орон нутгийн төлөөлөгчөөс бүрдүүлэх, дараагийн 76 нь

эмэгтэйчүүд, гуравдахь 76-д залуусыг багтааж, үлдсэн хоёр 76 суудалд чөлөөт өрсөлдөөн явуулж хэн ч сонгогдон орж болдог байхаар зохицуулалт хийхээр ярьж буй сурагтай. Нэг фракцийн нөлөөнд ордог ҮЗХ, Хяналтын зөвлөлийн гишүүдийг ч намын жирийн гишүүд сонгодог болсноор фракцийн улс төрөөс ангижирина гэж

# УЛС ТӨР

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

## Ж.АМГАЛАН:

# АЛИВАА ЗҮЙЛД СУДАЛГААТАЙ, УЛ СУУРЬТАЙ ХАНДАЖ СЭТГЭХГҮЙ БОЛ БИД ДЭЛХИЙГЭЭС ХОЦРОХ ГЭЭД БАЙНА



**Үргэлжлэл.**  
**Түүрүүч нь I нүүрт**

Манайд эдийн засгийн чиглэлийн судлаачид цөөнгүй боловч эдийн засаг хямарч байгаа нь бол энэ чиглэлийн судалгаа, судлаачид ямар түвшинд байгааг нэг талаас харуулж байгаа хэрэг, нөгөө талаасаа судлаачдын гаргаад ирсэн судалгааг зөв, үр дүнтэй ашиглах чадвар төрд, төрийн албан хаагчдад дутаад, төрийн санах ой хангалтгүй байна. Одоо төрийн албан хаагч болгон судлаачийн хэмжээнд ажиллах эрэгтэй болжээ. Дэлхий тийм болчихлоо. Асуудлыг мэдэхгүй, материал ашиглаж чадахгүй бол ажил урагшлахгүй, ер нь судалгаагүй, уялдаа холбоогүй нэг ч юм байхгүй болсон. Манайханы хэлдгээр шинжлэх ухаанч хандахгүй бол ямар ч ажилд ахиц гарахгүй, судалгааны байгууллагууд ч урагшлахгүй. Өнөөдөр гадны зээл тусламж, төсөл, хөтөлбөр болгон өөрсдөө судалгаагаа хийж байна. Энэ бол хамаг юм онгичоод хаячихдаг нэг талын аюул л даа. Манайд одоогоор 2010 оны хүн ам, орон сууцны улсын тооллогоос өөр ашиглах боломжтой судалгаа бараг алга, хүлээн зөвшөөрөгдөхгүй байна, гэд ч зөвшөөрөх хүсэлгүй байдаг бололтой. Шалтгаан нь биднийг, нийгмийг худал хуурмаг, найдваргүй, ёс суртахуунгүй бурангуй гэж хардаг, бид ч тэгж харагддагтай холбоотой байх. Дэлхийд бодлогын судалгаа хийдэг 6670 гаруй байгууллагатайгаа хойд хөршид 10 сая, урд хөршид 56 сая судлаач ажилладаг гэсэн тоо харж байсан. Гэтэл манай “Тинк танк” бүрэн ажиллахгүй, ашиглалт бага байна. Манай их хаан Хубилай XIII зуунд “Бичгийн мэргэдийн хүрээлэн” байгуулсан түүхтэй шүү дээ.

**Тэгвэл өнөөдөр төрийн удирдлагын хэмжээнд шинжлэх ухааныг, судалгааг хир үр дүнтэй ашиглаж байх шиг байна вэ?**

Төрийг ухаанаар, мэдлэгээр, ёс суртахуунаар удирддаг гэдэг. Энэ нь доголдоод ирэхээр нөгөө самрана гээч нь эхэлж байгаа нь тэр. Нөгөө хэлэх дуртай “Тинк танк” –ийг ашиглахгүй байна. Төрд ажилладаг хүн болгон өөрийгөө шүүдэг, бусадтай харьцуулдаг, биеэ засаад аваад явчихдаг тийм ёс суртахуунтай болохгүй бол мянган сайхан судалгаа, шинэ санаа, санах ойтой бодлого байгаад нэмэргүй юм. Ажиллаад байхад манайхан юманд судалгаагаар тооцоотой хандах хандлага тун бага, эрх мэдэл гээч хийрхэлд авчихдаг, тэгэхлээр бодлого яаж ч явах вэ дээ. Төрдөө биш төрд ажиллаж

байгаа хүмүүсийн буруу л даа. Вудро Вильсон гэдэг профессор 1887 онд “Улсын удирдлагын шинжлэх ухаан” гэдэг бүтээлдээ төрийн байгууллагуудын дэг журам, хөдөлмөрийн бүтээмж, ажил сайжруулах арга зам бол захиргааны шинжлэх ухаан гэж тодорхойлсон байдаг нь үнэн юм шиг санагддаг. Манайхан үүнийг ихэнх нь сонссон мэддэг боловч төрийн байгууллагад судалгаагаар хандлага, дэг жаяг журам, бодит бүтээмж, эрчтэй хүчтэй ажиллагаа гээд аль аль нь их сул, дархлаа муутай, дээрээс нь бэлтгэгдсэн боловсон хүчин дутмаг, биднийг нь холдуулчихдаг нэг тийм л үлбэр байдал ажиглагдах юм даа. Ийм байхад судалгаа, тооцоог ашиглаад бодлого гаргаад тууштай явна гэхэд бэрхшээлтэй. Яг одоо бол төрд судлах тооцоо асуудал ус агаар мэт хэрэгтэй тийм цаг ирлээ шүү дээ. Судалгаагаа зөв хийгээд төсөв нэмж авах биш хэмнэхээс ажлаа эхэлбэл нөөц бололцоо гараад ирдэг тал бий, бид 1990-ээд оны эхээр, 2008 оны үед тэгж л байсан.

**Төрд тооцоо судалгаагаар нийгмийн бодлого байдаг гэж ард түмэн итгэдэг. Гэтэл нийгэмд хямраад нийгэмд бүхмдэл үүсээд ирэхлээр тэр итгэл алдарч эхэлж байх шиг?**

Төрийн залгамж чанар гэж яриад байнааа даа. Залгамж чанар гэдэг нь бодлогоо тасалдалгүй залгуулаад ямар чанарын шаардлага стандарт тавигдана түүнд нь хүргээд явахыг хэлдэг. Засаглалын систем, чадварын мөн чанар нь юугаар яаж илэрч байгааг судлаачид төдийгүй ард түмэн олоод харчихдаг энэ нээлттэй цаг үед нарийн чамбай бодлоготой, хүчирхэг төр л болж өгөхгүй байгаа нь юундаа байна вэ?

Өнөөдөр дэлхийд бодлогоор бусдаас давуу байхын төлөөх чимээгүй дайн болж байна. Дайн бол улсын бодлогын үргэлжлэл гэж үздэг. Цаг хугацаа, гадаад дотоод нөлөөлөл гээд олон эрсдэлтэй замаас зөвийг нь сонгож явна гэдэг энэ эмзэг цаг үед тийм амар биш. Гадаад дотоод орчны сөрөг нөлөөнөөс

хамгаалагдсан байхыг аюулгүй байдал гэдэг шүү дээ. Төрийн бодлого болохгүй байна гэдэг нь төрд ажил хариуцсан та бид чадахгүй байна, чадсангүй л гэсэн үг. Болохгүй бүхэн төрийн буруу биш төрд ажилласан, одоо ажиллаж байгаа нөхдүүд болгож чадаагүй, чадахгүй байгаагаар холбоотой асуудал. Манай улс бол гаднаас элдэв самуунгүй, дотоод асуудлаа л цэгцэлчихэд болчихоор тийм тайван орчинтой улсын нэг шүү дээ. Одоо эдийн засгийн хямрал гэж яриад л байна. Эдийн засгийн төдийгүй ер нь хямрал болсон аюулгүй байдалд эрсдэл үүсгэж байдаг. Улсын экспорт, импорт, банк санхүү, мөнгөний бодлого, төсвийн аюулгүй байдал гээд бодлого алдаж болохгүй, хяналтаас гаргаж болохгүй олон юм бий. Мөнгөний бодлогыг л гэхэд таамаглах төсөөлөх аргагүй зөвхөн баримжаалсан судалгаанд дээрл суурилж ирэх болчихоод байна. Төрийн оролцоотой бүх юм аа л судалж, хянаж, тэр алдаа, олж хархгүй байгаа боломжийг илрүүлэн гаргаж ирэхгүй бол энэ хэвээрээ л явна.

**Хүнээс л бүх юм шалтгаалах нь ээ дээ ?**

“Өөр юунаас байхав дээ. Түүх, одоо үе ч тэгж л уншигдаж байгаа. Хаана ч адилхан. “Их хүн зам үлдээдэг, эвгүй хүн жалга үлдээдэг” гэсэн араб үг байдаг

шүү дээ. Эвгүй гэдэг нь юманд эв хавгүй, судалгаа тооцоогүй гэсэн санаа байх.

**Төрд ажиллах хүнийг бэлтгэдэг, шинжлэх ухаан тэр тусмаа судалгааг үндэслэл болгодог болгохгүй бол цаашид ямарч шалгуурыг нэг нөхөр төрийн албанд орж ирээд бужигнуулаад байх шинжтэй болох нь дээ?**

Төрийн ажилд мэдлэгээс гадна ёс суртахуун маш чухал. Төр муу асуудалтай тулгарахыг хүсдэггүй, үй олон асуудлыг төрд ажилласан хүмүүс л бий болгочихоод байна. Энэ хэний буруу вэ гэвэл төрд эрх мэдэлтэй ажил хийсэн этгээдүүдийн л буруу нөгөөх ёс суртахууных нь доголдол. Одоо болохгүй байгаа асуудлыг өөрчлөхийн тулд хаанаас эхлэх ёстой вэ гэвэл төр, засаг эсвэл нэг том таамаглах төсөөлөх аргагүй бэлтгэхээс, сонгохоос, чамбай судалж засч зарлуулахаас эхэлмээр байна. Аливаа асуудалд сонголт тохироо гэж байдаг. Сэтгэл санаа, ёс суртахуунаа нааштайгаар өөрчлөөд эхэлбэл иргэн нь, гэр бүл нь, нийгэм нь цаашлаад улс орон нь өөрчлөгдөдөг л явна. Нагаржунай айлдвар энэ тэрийг үзэж байхад бас л тийм юм билээ. Гаднаас зохицох зохицохгүй олон мэдээлэл аваад, туршлага нэрээр дууриагаад л ажлынхаа цаад зорилго агуулгыг

...Төрийн залгамж чанар гэж яриад байна аа даа. Залгамж чанар гэдэг нь бодлогоо тасалдалгүй залгуулаад ямар чанарын шаардлага стандарт тавигдана түүнд нь хүргээд явахыг хэлдэг. Засаглалын систем, чадварын мөн чанар нь юугаар яаж илэрч байгааг судлаачид төдийгүй ард түмэн олоод харчихдаг энэ нээлттэй цаг үед нарийн чамбай бодлоготой, хүчирхэг төр л улсаа авч явах нь мэдээж юм...

бүрэн мэдрээгүй төрийн албан хаагч олон байна. Ийм улс чинь бодлогогүй юм баахан хийчихээд, их мөнгө буруу аргаар олчихоод түүнийгээ засах гэж маань мэгзэм болж, ном хуруулж, түвдээс лам залахаас өөр яах юм бэ? Ийм хүмүүс төр авч явах, засах тухай ярих хэцүү шүү дээ. Биеэ зас, гэрээ зас тэгээд төрөө зас гээд дээд удаас мессеж өгсөөр байтал төрдгүй бүх шиг зүтгэж болохгүй биз дээ. Асуудлын гол алдаа ийм хэмжээнд л эргэлдээд байгаа юм бий үү. Төрсөн сэтгэгдэл, хий таамаглалаар баримжаалсан бодлого, судалгаанд тулгуурласан бодлого хоёрын ялгаа маш их. Судалгаагүй юм болгон аюулгүй байдалд эрсдэл дагуулдаг гэдгийг л мэдрэх хэрэгтэй байна.

“Олон хүн гадаад, дотоодод сураад үндэсний боловсон хүчин бэлтгэгдээд байгаа боловч үр дүн нэг л тааруухан байх юм?”

Үндэсний боловсон хүчин гэдэг чинь үндэсний эрх ашгаа ухаарч боловсорсон хүнийг хэлдэг. Тархна угаалгаад ирснийг нь хэлдэггүй байх. Үндэсний боловсон хүчний ажлын үр дүн төрийн ажлын хаана нь очиж эерэгээр тусаад байна гэдгийг бид бодож судлахад илүүдэхгүй. Зарим орон төрд ажиллах хүнд болох болохгүйг нь зааж өгөөд сайхан засаад өгч байна шүү. Тэднийг эх орондоо ирэхээр нь чөтгөрийн тойрогт оруулаад зөвруульчээд байна. Олон талын мэдлэг чадвар, төрмөл авьяастай иргэн манайд зөндөө байна. Улсын хөгжилд бэлтгэгдсэн боловсон хүчин гэдэг гол хүчин зүйл. Тэднийг олж ашиглах ажил үндсэндээ алга. Бэлтгэгдсэн хүмүүсээ гадагш нь маш их алдаж байна. Хүн амын гадагшлалт эрс өсчлөө. Ажиллаад байхад боловсролтой, юм боддог, гайгүй сэтгэгдэг нь нь явчихаад байна шүү дээ. Манайд судалгаанд суурилж шийдвэр гаргадаг практикийг хэвшүүлэх, төрийн алба хаагчдад нийгмийн сайн сайханы төлөө зүтгэх соёл, ёс суртахуун тогтоохгүй бол бидний зам ээдрээтэй хэвээр л байх болно. Энэ эдийн засгийн тогтворгүй байдал олон зүйлд нөлөөлж, хөдөлгөөнд оруулж хямрал ба боломжийн эх суурийг тавчихлаа. Энэ хямрал гээд байгаагийн эх үндэс нь цэвэр боловсон хүчний, ёс суртахууны л хямралаас болсон юм шиг харагдаад байгаа юм. Нийгэм дэх иргэний ухамсар гажчихсан байгааг ярихаас цаашгүй л байна. Бид хүнээ, нийгмээ хамгаалахын тулд яах вэ гэдгээ нэгдүгээрт анхаарах цаг болжээ. Эхний ээлжинд хүүхдүүдээ зөв хүн болгоход хүн бүрийн зөв оролцоо чухал байна. Гаднаас дуртай үедээ юуг ч эвдэх аюул эргэн тойронд их байгааг мэдрэхгүй, маргчих юм. Бид их том юм ярих тусам том эндүүрэл рүү орно. Бидний дархлаа нимгэн, их эмзэг гэдэг нь мэдрэгддэг. Т.Галсан найрагч “Бид цөөхүүлээ шүү дээ” гэдэг шүлэгэндээ бичсэн байдагтай адил. Аливаа зүйлд судалгаагаар, ул суурьтай хандаж бусадтай ядаж адил хэмжээнд сэтгэхгүй бол бид дэлхийгээс хоцрох гээд байна.

## МЭДЭЭЛЭЛ УИХ-ЫН ГИШҮҮД ЛОББИ БҮЛЭГ БАЙГУУЛАВ

УИХ-ын гишүүн О.Баасанхүү, Ж.Батзандан, Н.Энхболд, Д.Цогтбаатар, Д.Сарангэрэл, Х.Нямбаатар, Н.Амарзаяа, М.Билэгт нар Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх лобби бүлгийг байгуулсан байна. Энэ тухай албан бичгээ УИХ-ын дарга М.Энхболдод хүргүүлжээ. Энэхүү лобби бүлэг нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бүтэц зохион байгуулалт, тогтолцоог орчин үеийн шинэ шатанд гаргах, асуудлыг судлах, шаардлагагаар хөрөнгө санхүүг УИХ-аар батлуулах зорилготой аж. УИХ-ын нэр бүхий гишүүд лобби бүлэг байгуулснаар өнөөгийн нийгэмд тулгамдаад байгаа асуудлын нэг болох гэр бүлийн хүчирхийлэлийн асуудлыг төрийн хууль тогтоох дээд байгууллагын түвшинд авч үзэж, тогтолцоог боловсронгуй болгох, нийгмээрээ уг хууль бус үйл ажиллагааг таслах зөгсоход хувь нэмэр оруулах шаардлагагаар хэмээн үзжээ.

## ЧУУЛГАНЫ ТАНХИМААС ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ, ТОГТВОРЖУУЛАХ ХӨТӨЛБӨРИЙГ БАТЛАВ

УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар Эдийн засгийн хүндрэлийг даван туулах, тогтворжуулах хөтөлбөр батлах тухай УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцэн баталлаа. Төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийсэн байнгын хорооны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Д.Дамба-Очир танилцуулав. Эдийн засгийн байнгын хорооны санал дүгнэлттэй холбоотойгоор гишүүд санал хэллээ. УИХ-ын гишүүн Д.Сарангэрэл аж ахуйн нэгжүүдийнхээ өр төлбөрийг хойшлуулах, арга хэмжээ авах асуудлыг Засгийн газар анхааралдаа авах ёстой” гэв. Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт “Эдийн засаг хямарсан энэ үед татвар төлж чадахгүй, нийгмийн даатгалын өрөө төлж чадахгүй байгаа 4000 гаруй аж ахуй нэгжийн дансыг эхний ээлжинд нээсэн. Мөн хууль хяналтын байгууллагуудын хууль бусаар дарамт учруулж байгаа асуудлыг Засгийн газрын гишүүд хариуцан ажиллаж байна” хэмээн.

Харин УИХ-ын гишүүн М.Билэгт “Далай ламын айлчлалаас болж гадаадын зээл тусламж гацсан эсэх талаар тодрууллаа. С.Бямбацогт сайд “Далай ламыг Засгийн газар уриагүй. Манай Бурхан шашны төвийн урилгаар ирсэн гэж би хэвлэлээс уншсан. Монгол төр, шашин тусдаа үйл ажиллагаа

явуулдаг байгууллага” гэсэн тайлбар өгөв. Байнгын хорооны хуралдаанаас гарсан зарчмын зөрүүтэй саналуудаар санал хурааж, Эдийн засгийн хүндрэлийг даван туулах, тогтворжуулах хөтөлбөр батлах тухай УИХ-ын тогтоолын төслийг нийт гишүүдийн 82 хувийн саналаар баталлаа. Түүнчлэн чуулганы хуралдаанаар Төрийн болон албаны нууцын тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийсэн. Энэ хуулийн төслүүдийг Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачлан өргөн барьсан бөгөөд Төрийн олон байгууллагын нууцтай холбоотой асуудал хэлэлцэх учраас чуулганы хуралдааныг хаалттай горимд шилжүүлэх УИХ-ын гишүүн Ж.Энхбаяр горимын санал гаргаснаар хаалттай горимд шилжин хуралдлаа. Ийнхүү хаалттай хуралдаж, Монгол Улсын Ерөнхийлөгчөөс өргөн барьсан Төрийн болон албаны нууцын тухай хуулийн төслүүдийг хэлэлцээд төслийг дараагийн хэлэлцүүлэгт бэлтгэхээр байнгын хороонд шилжүүлсэн юм. Мөн Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Марракешийн хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулах тухай протоколд нэгдэн орох төслийг баталж, Олон улсын гэрээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн анхны хэлэлцүүлгийг хийлээ.

# ОНЦЛОХ ХУУДАС

## Сенсаацийн эргэн тойронг

# НЭР СОЛИГДООД ЮУ ӨӨРЧЛӨГДӨХ ВЭ

### “Мэргэжлийн”

гэх тодотголтой Засгийн газар

байгуулагдсанаасаа хойш нэр, хаяг өөрчлөх ажлыг эрчимтэй эхлүүлсэн. Өмнөх Засгийн газрын үед хэрэгжиж байсан зарим хөтөлбөрийн нэрийг нь өөрчлөн үргэлжлүүлснээс гадна зарим уул, ус, албан байгууллагын нэрийг хүртэл өөрчилсөн билээ. Тухайлбал, Хамтын тэтгэврийн тухай хуулийг Насны хишиг, “Сайн оюутан” хөтөлбөрийг “Орлоготой оюутан”, Хүүхдийн мөнгийг Хүүхдийн мөнгөн тэтгэмж, Эдийн засгийн хүндрэлийг даван туулах, тогтворжуулах хөтөлбөрийг Эдийн засгийг сэргээх хөтөлбөр, Сургалтын эзэлийн санг Боловсролын эзэлийн сан болгож өөрчилсөн. Гэх мэтчилэн төсөл хөтөлбөрийн нэрийг өөрчлөхөөс гадна зарим нэг газар, байгууллагын нэрийг өөрчилж буй асуудлыг энэ удаагийн “Онцлох хуудас” булангаараа онцолж байна.

### БХИС-ИЙГ ҮНДЭСНИЙ БОЛГОН ТОДОТГОЛОО


**2016.11.24:** Аюулгүй байдал, цэрэг, батлан хамгаалах чиглэлээр сургалт, судалгаа эрхлэх чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор Батлан хамгаалахын их сургуулийг Үндэсний батлан хамгаалахын их сургууль болголоо. Ингэснээр батлан хамгаалахын бодлого, эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийн “Сургууль төвт” тогтолцоо бий болох үндэс бүрдэж, дэлхийн олон орны ижил төрлийн сургалтын байгууллагатай адил төвшинд очих, ижил стандартаар сургалт явуулах бололцоотой болох юм. Мөн багшлах боловсон хүч чадваржиж мэргэшин, зохион байгуулалт, нөөцийн бодит дэмжлэг бий болно. Манай улсын батлан хамгаалах салбартай хамтын ажиллагаатай АНУ, БНХАУ, Турк, БНСУ зэрэг олон орны Үндэсний батлан хамгаалахын сургууль, бүс нутгийн болон олон улсын байгууллага, холбоотой харилцахад “Үндэсний” гэх тодотгол нь статусыг нь өргөж, илүү өргөн хүрээнд, харилцан итгэлцэхэд тулгуурлан адил төвшинд хамтран ажиллах нөхцөл, боломж бүрдэнэ гэж Батлан хамгаалах яам үзжээ.

### ЯАМД, АГЕНТЛАГУУДИЙН НЭРИЙГ ӨӨРЧЛӨВ

**2016.07.21:** Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнийг Ерөнхийлөгчид болон УИХ-ын даргад өргөн барьсан. Ерөнхий сайдын өргөн бариад байгаа бүтцээр яамд болон Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагуудын нэр дараах байдлаар өөрчлөгдөх юм байна. Тодруулбал, Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрыг “Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар”, Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрыг “Гадаадын иргэн, харьяатын газар”, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын асуудлын хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрыг “Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар”, Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд дэх Стандартчилал, хэмжил зүйн газрыг “Стандарт, хэмжил зүйн газар”, Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд дэх Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрыг “Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар”, Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрыг “Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар” болгон өөрчлөв. Мөн Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамыг Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Гадаад хэргийн яамыг Гадаад харилцааны яам, Хууль зүйн яамыг Хууль зүй, дотоод хэргийн яам, хоёр яамыг нэгтгэж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Уул уурхайн яамыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн яамыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Эрүүл мэнд, спортын яамыг Эрүүл мэндийн яам хэмээн нэрийг нь өөрчлөх асуудлыг УИХ-ын нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн дэмжсэнээр өөрчилсөн юм.

### ХЭНТИЙ ХАН УУЛЫН НЭРИЙГ БУРХАН ХАЛДУН УУЛ ГЭЖ ӨӨРЧИЛНӨ

**2016.11.16:** Засгийн газрын өнгөрөгч долоо хоногийн хуралдаанаар “Хэнтий хан уулын нэрийг Бурхан Халдун уул гэж өөрчлөх тухай” УИХ-ын тогтоолын төслийг БОАЖ-ын сайд Д.Оюунхорол оруулж, хэлэлцүүлсэн нь олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон нийгмийн сүлжээгээр шүүмжлэл дагуулаад байгаа. Үнэндээ “Хэнтий хан уулын нэрийг Бурхан Халдун уул гэж өөрчлөх тухай” УИХ-ын тогтоолын төслийн танилцуулгад дурьдсанаар, Дэлхийн өвөөр бүртгэгдсэн Бурхан халдун уул нь Монгол Улсын газрын зурагт албан ёсоор тэмдэглэгдээгүй байдаг аж. Учир нь, ЮНЕСКО-гийн Дэлхийн өвийн хорооны 39 дүгээр чуулганы хуралдаанаар “Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутаг” гэсэн өвийг хэлэлцэн баталж, Дэлхийн соёлын өвд бүртгэсэн. Дэлхийн өвөөр бүртгүүлэхийн өмнө Дэлхийн өвийн төвөөс Байгаль хамгаалах олон улсын холбоо (IUCN) болон Хөшөө дурсгал, дурсгалт газрын олон улсын зөвлөл (ICOMOS) гэсэн хоёр зөвлөх байгууллагаар үнэлгээ хийлгэхээр болж, 2014 оны есдүгээр сард дээрх хоёр байгууллагаас тус бүр нэг эксперт манай улсад ирж, нэр дэвшиж байгаа газар нутгийг судлан танилцаад зарим үл ойлголцох асуудал гарч байгааг тэмдэглэсэн байна. Тодруулбал, Бурхан халдун уулын нэр нь Монголын газрын зурагт тэмдэглэгдэж байгаагүй болон зарим эрдэмтэн, судлаач хэд хэдэн байршилд Бурхан халдун уул байгаа гэсэн зөрүүтэй мэдээллээс шалтгаалан Бурхан уулын байршил тодорхойгүй, нэр дэвшүүлж байгаа уул нь Бурхан халдун гэдэг нь баттай нотлогдохгүй байна гэж үзэж байжээ. Тиймээс өмнө нь үүсч байсан тодорхойгүй, зөрүүтэй байдлыг арилгах шаардлага манай улсад тулгарч байгаа учир Хан Хэнтийн нурууны Х=5402914.739, Y=353760.779 /B=48°45'43.3844, L=109°00'36.1315/ солбицолд байгаа д.т.д. 2,361.5 метрт орших “Хэнтий Хан уул” гэсэн тоот өндөрлөгийн албан ёсны нэрийг “Бурхан халдун” уул болгож өөрчлөх нь зүйтэй гэж үзжээ. Уг саналыг БОАЖЯ-наас боловсруулж, Газрын тухай хуулийн дагуу хилийн цэс, газар усны албан ёсны нэрийг зөвхөн УИХ баталдаг учир ийн тогтоолын төсөл өргөн барих болсон байна. Тогтоолын төсөл батлагдсанаар Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутгийг хамгаалах Дэлхийн өвийн газрын Менежментийн төлөвлөгөөг баталж хэрэгжүүлэх юм байна. Дээрх тогтоолын төсөл батлагдсанаар Монгол Улсын газрын зураг дахь “Хэнтий Хан уул” гэснийг “Бурхан халдун” уул болгож өөрчлөн солих ажил хийх аж.



### ЧИНГИСНИЙ ТАЛБАЙГ СУХБААТАРЫН ТАЛБАЙ БОЛГОЖ ӨӨРЧЛӨВ

**2016.08.16:** Нийслэлийн ИТХ дахь МАН-ын бүлгээс Сүхбаатарын талбайн нэрийг Чингисийн талбай болгож өөрчилснийг эсэргүүцэж, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд нэхэмжлэл гаргаад байсан. Тэгвэл шүүхээс Төв талбайг хуучин нэрээр нь буюу Сүхбаатарын талбай болгон өөрчлөх шийдвэр гаргажээ. Нийслэлийн ИТХ-ын 2013 оны долдугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар Сүхбаатарын талбайн нэрийг Чингисийн талбай болгон өөрчилсөн. Ингэж шийдвэрлэсэнээс хойш МАН-ын залуус Сүхбаатарын талбайн нэрийг эргэн сэргээхээр шүүхэд хандаад байсан юм. Харин уг асуудлаар өмнө нь анхан шатны шүүхээс “Сүхбаатарын талбайг Чингисийн талбай болгож өөрчилсөн нь буруу” гэх дүгнэлтийг гаргаж байсан удаатай. Гэвч тухайн үед хотын удирдлагууд хүлээж аваагүйн улмаас МАН-ын бүлэг давж заалдаад байсан нь энэ аж.

### ҮНДЭСНИЙ ДУУ, БҮЖГИЙН ЭРДМИЙН ЧУУЛГЫГ ҮНДЭСНИЙ УРЛАГИЙН ИХ ТЕАТР БОЛГОВ

**2016.11.02:** Монгол Улсын Засгийн газрын ээлжит хуралдаан болж, Үндэсний дуу, бүжгийн эрдмийн чуулгын нэрийг өөрчилж Үндэсний урлагийн их театр болгов. Ийнхүү нэрийг нь өөрчилж, их театр болгосноор Монголын олон үндэстэн, угсаатны ардын урлагийг баяжуулан хөгжүүлж байгаага улам өргөжүүлж, урын сангаа бүрэн ашиглан, гадаад харилцаа, хамтын ажиллагаанд дэвшил нь гарч, олон улсад өрсөлдөх боломж нэмэгдэнэ гэж мэргэжлийн байгуулагынхан үзэж буйгаа Засгийн газрын хуралдаанд тайлбарлалаа. Өөрөөр хэлбэл, 70 гаруй жилийн түүхтэй Үндэсний дуу бүжгийн эрдмийн чуулга өнөөдөр концертын байгууллагаас театрын байгууллага болж хөгжсөн, гадаадын улс орнуудынхаа ижил төрлийн байгууллагатай статус нэг болох шаардлагатай байгаа юм. Үндэсний дуу, бүжгийн эрдмийн чуулга 1945 онд “Эстрада концертын товчоо” нэртэйгээр байгуулагдсан. Анх 19 дуучин, 27 хөгжимчин, 13 бүжигчин, уран сайхны удирдагч, багш гээд нийт 62 уран бүтээлтэй байсан бол одоо 24 дуучин, 64 хөгжимчин, 48 бүжигчин болон багш, удирдлага бүхий 190 гаруй хүнтэй байгууллага болжээ.

## Сэтгүүлчийн өнцөг

# НЭР СОЛИХ ЧИНЬ БИЗНЕС ЮМ БИШ ҮҮ

Н.ПУНЦАГБОЛД

Монголд төрийн залгамж халаа гэж огт алга. Төр гэдэг уг нь залгамж чанартай, бодлоготой байх ёстой. Нэгдсэн шүү дээ. Тэдэн он хүртэлх хөгжлийн зорилт, бодлого гээд гаргачихдаг, ямар ч нам ялсан, хэн гэдэг дарга, сайдтай болсон ч бай тэр зорилт, зорилгынхоо төлөө нэгдсэн бодлогоо бариад ажилладаг л байх ёстой. Уг нь манай улс ганц нэг бодлогын бичиг баримт гаргадаг ч түүнийгээ ширээнийхээ нүдэнд хийгээд л мартдаг бололтой юм. Тиймдээ ч дарга солигдохоор л өөрийнхөө бодлогыг хэрэгжүүлэх гэж оролдож, өмнөхөө үгүйсгэдэг

балай тогтолцоотой болчихоод байна. Энэ засаг төр ч гэсэн яг ийм маягаар ажиллаж байгаа. Дорвитой ажил хийж, улс орноо өөд нь татаж чадаагүй байж баахан байгууллага, газрын нэр солиод л, түүнийгээ янз бүрээр тайлбарлаж байна. За тэр төв талбайг Сүхбаатар гэнэ үү, Чингис гэнэ үү хамаа алга. Дуртайгаараа нэрлэнэ биз. Уулын нэр солих ч өнгөрч, дураараа л болог. Харин байгууллагын нэр солихоор улсаас баахан мөнгө урсана биз дээ. Тамга тэмдэг, албан бичиг, хаягнаас авахуулаад ажилчдын нэрийн хуудас гээд л арилж өгнө. ҮДБЭЧ-ын нэрийг сольж Үндэсний урлагийн их театр болгосон. УДЭТ-ын “бөөр”-нд

наалдсан Үндэсний урлагийн их театраар ч яах юм билээ. Дотор нь ажиллаж байгаа хэдэн хүмүүс, үндэсний урлагийн төлөө сэтгэл зүрхээ зориулж яваа хүмүүс л жаахан баярлах барьж өгчихөөд, дараа нь нэрийг сольсон бол сүртэй байхгүй юу. Мөн Засгийн газар солигдох болгонд яамдын нэр солигдог. Тогтмол хэдэн яамтай, нэр ус нь солигддоггүй байвал яасан юм. Нэр солигдохын тоогоор л улсын мөнгө урсана. Тамга тэмдэг, хаяг, албан бичигнээс авахуулаад л. Тэр болгонд төсвийн мөнгөнөөс урсгана биз дээ. Дээрээс нь дарга, албан хаагчдынх нь нэрийн хуудсыг хүртэл улсын мөнгөөр хэвлэдэг

байж таарна. Ингээд л өнөөх урсгал зардал чинь автоматаар нэмэгдээд байгаа юм. Энэ мэтээ больчих хэрэгтэй шүү дээ. Нэр ус нь өөрчлөгддөггүй, бодлого нь үргэлжилдэг 9-10 яамтай байхад л болоод явчихна биз дээ. Гэтэл зөвхөн яам, агентлаг, газруудын нэрийг солиод л нэг утгаараа бизнес хийгээд байна. Одоо бүр сүүлдээ сургуулиудын нэрийг сольж эхэллээ. БХИС-ийн нэр хэнд гай болчихоод өөрчлөх гээд байгаа юм, бүү мэд. Үндэсний гэсэн үг нэмсэн ч яалаа, байсан яалаа. Манай улсын батлан хамгаалах салбартай хамтын ажиллагаатай АНУ, БНХАУ, Турк, БНСУ зэрэг олон орны Үндэсний батлан хамгаалахын сургууль,

бүс нутгийн болон олон улсын байгууллага, холбоотой харилцахад “Үндэсний” гэх тодотгол нь статусыг нь өргөж, илүү өргөн хүрээнд, харилцан итгэлцэлд тулгуурлан адил төвшинд хамтран ажиллах нөхцөл, боломж бүрдэнэ гэж үзэж байгаа юм гэсэн. Жаахан зуларахад, энэ бол ердөө л нэг тайлбар. Тийм л байсан юм Монголын Үндэсний гээд нэрлэхгүй яасан юм. Бүр бусад улс орны Батлан хамгаалахын сургуулиудаас хүртэл ялгарна биз дээ. Монголын гээд. Тэгэхгүй зүгээр л Үндэсний батлан хамгаалахын гэхээр чинь Батлан хамгаалахын их сургууль гэдгээсээ нэг их ялгарч чадахгүй

байна. Харин ч нэр сольсноор улсын төсвөөс мөнгө хумсална. Цаашлаад оюутнуудад, эцэг, эхчүүдэд дарамт болоод л иж байгаа юм. Нэр хаягаа солихоос авахуулаад л олон зүйлд мөнгө хэрэг болно шүү дээ. Хувцсан дээрх сургуулийн нэрийг солиход хөөрхөн хэдэн төгрөг хэрэг болно. Тэрийг нь оёдог газар хэд байгаа билээ. Ингээд л бас бизнес болж харагдаад байна. Ард иргэдийнхээ халаас руу гар дүрж байгаа л гэсэн үг. Яахав, дарга нар бол нэр сольж байгааг яаж ч тайлбарлаж болно. Гагцхүү цаана нь гарч байгаа үр дагавар, урсч байгаа их мөнгийг л бодоод үзэхэд бизнесийн сэдэлтэй л гэж хардахаас өөр арга алга даа.

# ДЭЛХИЙ

## 1.3 сая СОЛОНГОСЧУУД ДАХИН ЖАГСЛАА

БНСУ-ын Ерөнхийлөгч Пак Гын Хегийн найз Чой Сун Шил төрийн тэргүүнтэй дотно байдлаа ашиглан тус улсын томоохон корпорацнудаас их хэмжээний хөрөнгийг хандив нэрийдлээр өөрийн сандаа төвлөрүүлдэг байсан нь ил болж, баривчлагдсан билээ. Улмаар Пак Ерөнхийлөгч сэжигтэнг улс төрийн үйл хэрэгтээ оролцуулж, хэлэх үгээ хүртэл зааварлуулдаг байсан нь ийм хэмжээний авлига авахад хүргэсэн гэх дуулиан тус улсад хүчээ авч эхэлсэн юм. Түүгээр зогсохгүй прокурорын газраас Ерөнхийлөгчийг тус улсын түүхэн дэх анхны гэмт хэрэгтэн удирдагч гэдгийг зарласнаар Сөүл хотноо хоёр дахь удаагийн томоохон эсэргүүцлийн жагсаал зохион байгуулагдлаа. Өмнө нь Сөүлд нэг сая хүн эсэргүүцлийн жагсаал зохион байгуулж байсан бол өнгөрөгч бямба гаргт болсон жагсаалд 1.3 сая хүн оролцжээ.

Тэд гартаа лаа барьж эсэргүүцлээ илэрхийлсэн бөгөөд мөн өдрийн 20:00 цагт бүгд лаагаа нэгэн зэрэг унтраасны дараа нэг минут хэртэй хугацааны дараа дахин лаагаа асаажээ. Жагсагчид Пак Гын Хе Ерөнхийлөгч суудлаасаа буух хүртэл эсэргүүцлийн гал хэзээ ч унтрахгүй гэдгийг үүгээр илэрхийлэхийг хүссэн байна. Их Сургуулийн оюутнууд, шашны байгууллагуулынхныг хүртэл нэгтгэсэн энэ удаагийн жагсаал тайван замаар явагдсан бөгөөд энэ нь 1987 оноос хойшхи хамгийн өргөн хүрээг хамарсан эсэргүүцлийн хөдөлгөөн болж байна.

## Сингапур ОХУ-тай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулж магадгүй

Евразийн эдийн засгийн холбоо болон Сингапур ирэх оны сүүлээр чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулж, 2018 оны эхний хагаст соёрхон баталж магадгүй байна гэж ОХУ-ын Ерөнхий сайдын тэргүүн дэд орлогч Игорь Шувалов мэдэгдэв. “Өнгөрсөн тавдугаар сард Сочи хотод болсон АСЕАН-ОХУ-ын уулзалтын үеэр АСЕАН-ы гишүүн орнууд ОХУ-тай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах санал дэвшүүлсэн бөгөөд Сингапуртай ийм төрлийн хэлэлцээр байгуулах асуудлыг эн тэргүүний зорилт болгохыг ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин зарлигдсан.

Тиймээс ирэх оны сүүлээр Сингапуртай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулж, 2018 оны эхний хагаст соёрхон батлах боломж бололцоо бидэнд байна” гэж тэрбээр ОХУ-Сингапурын Засгийн газар хоорондын комиссын өргөтгөсөн хуралдааны үеэр мэдэгджээ. Мөн тэрбээр ОХУ, Сингапур нь АСЕАН дахь гол түншүүд гэж дурдаад, “Цаг хугацааны асуудал хүндэрлэж байгаа боловч хэлэлцээрийг байгуулах боломжтой. Бид өөрсдийн зүгээс чадах бүхнээ хийнэ” гэсэн байна. Харин Сингапурын Ерөнхий сайдын орлогч Тарман Шанмугаратнам, Сингапур ОХУ-тай эдийн засаг, худалдааны чиглэлээр хамтран ажиллах хүсэлтэй байгаа боловч хоёр улс өөрт байгаа бүх боломж бололцоогоо ашиглахгүй байна гэж мэдэгдлээ.



# КУБЫН ХУВЬСГАЛЫН ЭЦЭГ ТААЛАЛ ТӨГСЛӨӨ

Б.ДАВААХҮҮ

20 дугаар зууны сүүлчийн хагаст дэлхийн хүчирхэг, нөлөө бүхий удирдагчдын нэг гэгдэж явсан Кубын удирдагч Фидель Кастро энэ сарын 25-ны өдрийн орой тус улсын нийслэл Гавана хотод 90 насандаа таалал төгслөө. Түүний дүү Рауль Кастро энэхүү гашуудлын мэдээг шөнө дундын үед орон даяар зарласан байна. Тэрбээр “Кубын хувьсгалын удирдагч арваннэгдүгээр сарын 25-ны өдрийн оройн 22:29 цагт таалал төгслөө. Түүнийг өөрийн хүслийн дагуу гашуудлын ёслолыг маргааш хийнэ” хэмээн мэдэгджээ. Улстөрийн ертөнцийг хэзээ ч орхихгүй хэмээн нэгэн удаа дурсч байсан тэрээр 2006 оны долдугаар сард нарийн гэдэсний яаралтай мэс засалд орж, эрх мэдлээ өөрийн дүү Рауль Кастроод шилжүүлж байсан удаатай. Харин Рауль төрсөн ахыгаа залгамжлан Куба улсыг толгойлохдоо эдүгээг хүртэл баримталж ирсэн улс төрийн бодлогод эргэлт хийж, АНУ-ын Засгийн газартай харилцаагаа зөөлрүүлэх алхмыг хийсэн юм.

2014 оны арванхоёрдугаар сард АНУ-ын өнөөгийн тэргүүн Барак Обама Кубын тэргүүнтэй уулзаж, хагас зуун жилийн турш царцсан харилцаандаа эргэлт хийж, дипломат харилцаагаа сэргээсэнээр зарлан дэлхий нийтийг гайхшруулж байлаа. Чидун жимсний өнгөтэй хувцас, сахал, навчин тамхи энэ бүгд Фидель Кастро агсны дэлхий нийтэд танигдсан гол имиж. Тэрээр дотоодын тэрс үзэлтнүүдийн эсрэг хатуу бодлогоо үргэлжлүүлж ирсний зэрэгцээ, гадаад ертөнцөд

...Фидель Кастро нас барсантай холбоотойгоор Куба улс төрийн далбаагаа хагас бөхийлгөж, улс орон даяар гашуудал зарласан. Мөн дэлхийн удирдагчид сайн найз, нөхрөө алдсан хэмээн түүнийг санан дурсаж, гашуудаж буйгаа илэрхийлж байхад эсрэгээр АНУ-ын Флорида мужийн Миамид куба гаралтай америкчууд баярлан цэнгэсэн гэнэ...

түүнийг АНУ-ын Засгийн газрыг эсэргүүцэгч нэгэн гэдгээр нь анддаггүй байлаа. Хоёр жилийн өмнө АНУ, Куба улсын харилцаанд эргэлт гарч, дипломат харилцаагаа сэргээх үед Барак Обама Кубад тус улсын эсрэг авсан хориг арга хэмжээгээ цуцалж, куба иргэдийг дэмжих арга хэмжээг авч хэрэгжүүлэх үе ирснийг онцолж байв. Ийнхүү кубын иргэд ядуурал, зовлон дунд хагас зуун жилийг туулсны эцэст хэдийгээр өөрийн удирдсан хувьсгал үнэ

цэнээ алдсан ч Фидель Кастро сүүлчийн удаа “улс төрийн сөргөлдөөн”-т тоглоомд ялалт байгуулсан нь энэ байлаа.

Фидель Кастро агсныг ирэх сарын 4-ний өдөр нутаглуулах ажээ. Улмаар тэр өдрийг хүртэл улс орон даяар гашуудал зарласан байна. Энэ хугацаанд Гавана хотын хувьсгалын талбайд олон нийтийг хамарсан томоохон цуглаан хийх гэх мэт гашуудлын үйл ажиллагаанууд зохион байгуулагдах юм байна. Нийслэл Гаванахотод байрладаг төрийн байгууллагуудын дэвээр дээр байрлах төрийн далбаануудыг өнгөрөгч бямба гарагаас эхлэн бөхийлгөж, гашуудлын үйл ажиллагаа олон нийтийг хамарч, иргэд нь сүмд очин гашуудлын үйл үйлдэх болжээ. Сүмд мөргөсөн нэгэн эмэгтэй “Фидель Кастро кубын ард иргэдийн төлөө бүхий л хүчээ дайчилсан. Бид түүний үйл хэргийг хэзээ ч мартаж өсгүй” гэж ярьсан байна.

Дэлхийн удирдагчид юу хэлэв

Кубын хувьсгалын эцэг гэгддэг Фидель Кастро таалал төгслөө гэх мэдээлэл дэлхий нийтэд тарсны дараа дэлхийн нөлөө бүхий удирдагчид гашуудлын үгс илгээж эхэллээ. Тухайлбал, энэ оны гуравдугаар сард Кубад түүхэн айлчлал хийсэн АНУ-ын төрийн тэргүүн Барак Обама “Энэхүү ер бусын хүний хөрш орныхоо иргэдэд ялангуяа дэлхий нийтэд үзүүлсэн асар их хүч нөлөө нь түүхэнд тэмдэглэгдэн үлдэх биз ээ” гэсэн бол тус улсын 45 дахь Ерөнхийлөгчөөр тодроод буй үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан Доналд

Трам Фидель Кастро агсныг “харгис дарангуйлагч” гэдгийг тодотгожээ. Тэрбээр “Фидель Кастро бол аллага, хулгай дээрэм, санаанд багтамгүй зовлон, ядуурал, хүний эрхийг үгүйсгэгч гэдгээр дурсагдана” хэмээн мэдэгдэлдээ дурьджээ. Харин ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин “Түүний ердөө нэр нь л орчин үеийн дэлхийн нэгэн цаг үеийн түүхийн бэлгэдэл гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой. Фидель Кастро ОХУ-ын чин үнэнч, итгэлт нөхөр байсан” гэж өгүүлсэн байна.

Мөн манай өмнөх хөрш болох БНХАУ-ын дарга Си Зиньпин төрийн мэдлийн телевизээр дамжуулан мэдэгдэл хийсэн бөгөөд энэ үеэр “БНХАУ-ын ард түмэн хамгийн сайн нөхрөө алдлаа” гэжээ. Сирийн Ерөнхийлөгч Башар ал Ассад “Аугаа удирдагч Фидель Кастро империализм буюу түрэмгийлэлийн эсрэг хэдэн арван жилийн турш ард түмэн, улс орноо тэргүүлэн тэмцсэн” хэмээсэн бол Ромын пап Францис “Түүнийг амар тайван нойрсуулахын төлөө бурханд залбирах болно” гэсэн байна. Харин НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Бан Ги Мүн Фидель Кастрогийн удирдлага дор Кубын боловсрол, эрүүл мэндийн салбарт асар их дэвшил гарсаныг онцолжээ. Энэ мэтээр дэлхийн удирдагчид өөр өөрсдийнхөөрөө үзэл бодлоо илэрхийлсээр байна.

Миамид эсрэгээр баяр тэмдэглэв

Фидель Кастро нас барсантай холбоотойгоор Куба улс төрийн далбаагаа хагас бөхийлгөж, улс орон даяар гашуудал зарласан.

Мөн дэлхийн удирдагчид сайн найз, нөхрөө алдсан хэмээн түүнийг санандурсаж, гашуудаж буйгаа илэрхийлж байхад эсрэгээр АНУ-ын Флорида мужийн Миамид куба гаралтай америкчууд баярлан цэнгэсэн гэнэ. Кубын хувьсгалын эцэг таалал төгссөнийг Рауль Кастро зарласны дараа буюу энэ сарын 26-ны өдрийн өглөө тэд баярлаж, цэнгэн бүжиг наадам болсон байх бөгөөд “Куба чөлөөлөгдлөө”, “эрх чөлөө, эрх чөлөө” хэмээн хашгирч домогт удирдагч нас барсны “баяр”-ыг тэмдэглэсэн байна. Флорида мужийн Миами хотод хамгийн олон куба гаралтай америкчууд амьдардаг ажээ. Кубын коммунист намын дарангуйлалаас зугтан АНУ-д дүрвэсэн хүмүүс сэтгэлийн хөдлөлөө илэрхийлж, машинныхаа дохиоллыг дуугаргаж, төмпөн сав, бөмбөр цохин, зарим нь бүжиглэж, зарим нь байрын нулимс унаган Куба улсын төрийн далбааг намуруулсан байна.

Энэ цуглаанд оролцсон 20 жилийн өмнө АНУ-д дүрвэж ирсэн гэх шашны номлогч Пабло Аренсибиа “Хүмүүсхүний нас барсан талаарх мэдээллийг сонсоод баярлана гэдэг үнэхээр харамсмаар явдал байх. Гэхдээ тэр хүн нь Фидель Кастро бол өөр хэрэг” гэж ярьжээ. Үүгээр зогсохгүй баярлан цэнгэж буй агшнаа фэйсбүүк хуудсаараа шууд дамжуулан Кубад суугаа найз нөхөд гэр бүлийнхэндээ үзүүлсний зэрэгцээ инстаграмм, скайп зэрэг нийгмийн сүлжээнд ч байршуулсан байжээ. АНУ-д хоёр сая орчим куба иргэд амьдардаг гэсэн тоон баримт байдаг бөгөөд тэдний 70 орчим хувь нь зөвхөн Миамид амьдардаг байна.



## ТАЛ НУТГИЙН ЦАХИМ МЭДЭЭЛЭЛ



**MMINFO АПП**  
Тал нутгийн өдөр тутмын мэдээ мэдээлэл таны гарт...

 TATAХ PLAY STORE
  TATAХ APP STORE



# ШУУРХАЙ МЭДЭЭ

## 34 МЯНГА ГАРУЙ ЭЗЭМШИГЧ, АШИГЛАГЧ ШИНЭЭР БҮРТГЭГДСЭН

Н.БАТЗАЯА

*"Газрын бирж" хэлэлцүүлэг энэ сарын 24-нд боллоо. Энэхүү хэлэлцүүлэгт БХБЯ,ХЗЦХЯ,СЯ,ХХААХҮЯ,Үндэсний хөгжлийн газар, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар, Нийслэлийн Газрын алба, Төв, Сэлэнгэ аймгийн Газрын харилцаа, хот байгуулалтын газрын холбогдох албаныхан болон судлаачид оролцсон юм. Энэ үеэр БХБЯ-ны Хот байгуулах газрын харилцаат бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргаас Б.Гүнболдоос зарим зүйлийг тодрууллаа.*

### -Одоогийн байдлаар хэчнээн иргэн газар эзэмшигчээр бүртгүүлээд байна вэ?

Юуны өмнө хэлэлцүүлгийнхээ талаар мэдээлэл өгөх нь зүйн хэрэг байх. Манай улс газрын цахим биржтэй болох эрх зүйн зохицуулалтыг 2002 онд Газрын тухай хуульд тусгасан байдаг. Журмаа боловсруулсан учраас бирж ажиллаж эхлэхэд эрх зүйн бүрэн боломжтой бүрдсэн. Энэ хэлэлцүүлгийн дараа Засгийн газрын хуралдаанаар орох ётстой байгаа. Ер нь манай улсад өнгөрсөн жилийн байдлаар 46 мянга гаруй газар өмчлөгч, 34 мянга гаруй эзэмшигч, ашиглагч шинээр бүртгэгдсэн гэсэн статистик байдаг.

### "Газрын цахим бирж" гэхээр иргэд сайн мэдэхгүй байх. Энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхгүй?

Газрын цахим бирж байгуулснаар одоо тулгамдаж буй олон асуудлыг шийдвэрлэх юм. Тухайлбал, газрыг шударга бус харьцангуй үнэлдэг, аль эсвэл мөнгөтэй, эрх мэдэлтэй нь дуудлага худалдааг авлигаар өөрийн болгодог гэх мэтчилэн олон асуудлыг шийдвэрлэх боломжтой хэмээн харж байгаа. Ер нь цахим биржээр дамжуулан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа,

төсөл сонгон шалгаруулалт, дуудлага худалдаа, төсөл лавлагаа мэдээллийн сонгон шалгаруулалтаар үйлчилгээг цахим хэлбэрээр хургэнэ. Ингэснээр наад зах нь газрын дуудлага худалдааг танхимаар зохион байгуулж, танил тал, мөнгө төгрөгөөр наймаашид явдлыг арилгаж, цэгцлэх боломж бүрдэнэ. Мөн газар болон дээрх үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнэ ханш, эрэлт хэрэгцээ, ханган нийлүүлэлтийг тогтворжуулах, энэ төрлийн мэдээллийг иргэдэд нээлттэй хүргэх, газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг биржээр зохицуулах юм. Хамгийн чухал нь газрын бодит үнэлгээг бий болгох ач холбогдолтой.

### "Газрын цахим бирж" газрын дуудлага худалдааг зохион байгуулахаас гадна өөр ямар үйлчилгээг иргэдэд үзүүлэх вэ?

Газрын цахим бирж таван төрлийн үйлчилгээ үзүүлнэ. Нэгдүгээрт, төрийн өмчийн газрыг дуудлага худалдаа болон төсөл сонгон шалгаруулах журмаар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах үйлчилгээг хүргэх юм. Хоёрдугаарт, иргэн, хуулийн этгээдийн газар эзэмших эрхийг

дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтаар бусдад шилжүүлэх, зуучлах мөн Монгол Улсын иргэний өмчилсөн газрыг худалдана. Түүнчлэн газар эзэмших эрхийн барьцааны лавлагаа гаргах, газар, үл хөдлөх эд хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээллийн санг эрхлэх, олон нийтэд мэдээлэх гэсэн үндсэн үйлчилгээг иргэдэд үзүүлнэ.

### -Цахим бирж хөгжих нь ямар ач холбогдолтой вэ?

Манай улсад газрын цахим бирж идэвхтэй хөгжсөнөөр Засгийн газар, хувийн хэвшлийнхэн шаардлагатай хөрөнгө оруулалтаа биржээр дамжуулан олж авах боломжтой. Мөн ипотекийн зээлийн урьдчилгаа босгох, газраар баталгаажсан үнэт цаас бий болгох зэрэг эдийн засгийн олон үр ашгтай.

### -Хэзээнээс ажиллаж эхлэх вэ?

Өнөөдөр журмын төслийг хэлэлцүүлж байна. Хэлэлцүүлгийн дараа Засгийн газрын хуралдаанаар оруулна. Тэгж байж газрын цахим бирж хэзээнээс ажиллах нь тодорхой болно.

### СЭРЭМЖЛҮҮЛЭГ

## АВТОМАШИНЫ ХУЛГАЙЧААС БОЛГООМЖИЛ

Цагдаагийн ерөнхий газраас хулгайч нараас болгоомжлохыг анхаарууллаа. Тодруулбал, Сүхбаатар дүүргийн VIII дугаар хорооны "III дугаар байрны гадна тавьсан автомашины хучлагыг хулгайлж байна" гэсэн мэдээлэл цагдаагийн газарт иржээ. Дуудлагын дагуу шалгахад, 16 настай Д нь бусадтай бүлэглэн автомашины хучлага хулгайлж байсныг үйлдэл дээр нь илрүүлсэн аж. Хэргийг Сүхбаатар дүүргийн цагдаагийн I дүгээр хэлтэс шалгаж байна. Тиймээс цагдаагийн газраас автомашины хулгайчдаас болгоомжлохыг жолооч нарт анхааруулсан юм.



## Сүхбаатарчууд зуслангийн 16 км замын цасыг цэвэрлэлээ

Энэ амралтын өдрүүдэд Сүхбаатар дүүргийн ажил хариуцсан албан хаагчид Сахитын Зунжин худалдааны төвөөс Шаргаморьт, Санзайн зам, Хандгайтын зуслан хүртэлх 16 км автозамын болон хажуугийн замын цас мөсийг цэвэрлэлээ. Нийслэлийн Засаг даргын уриалга, Сүхбаатар дүүргийн Засаг даргын захирамжаар байгууллага хамт олон өөрсдийн хариуцсан зам талбайн цас мөсийг цэвэрлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Өнөөдрийн байдлаар зуслангийн замд Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ-ын 45 зам талбайн үйлчлэгчид, Онцгой байдлын хэлтсийн 15 албан хаагч, дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг тохижилт, үйлчилгээний компаниудын хог тээврийн 20 ачигч жолооч нар нэг бобкат, хоёр ковч, хоёр камаз машин ашиглан цасаа цэвэрлэж байна. Энэ үеэр дүүргийн Засаг дарга Х.Болормаа газар дээр нь ажлын явцтай танилцаж, цас мөс цэвэрлэх ажлаа эрчимжүүлж, төлөвлөсөн хугацаандаа цэвэрлэн дуусгахыг үүрэг болгов.

## 90 тонн цас мөс цэвэрлэлээ

Нийслэлийн Засаг дарга болон дүүргийн Онцгой комиссын дарга Д.Пүрэвдаваагийн даалгаврын дагуу өнгөрсөн баасан гарагт Баянзүрх дүүргийн Нийтлэг үйлчилгээний газрууд Доржийн гудамжаас Улаанхуарангийн уулзварын цас мөсийг цэвэрлэлээ. Нийт 31.560 метр квадрат талбайн 90 тонн цас мөсийг цэвэрлэж, 11 авто машинаар зөөж тээвэрлэв. Дүүргийн Засаг даргын Тамгын газраас цас, мөс цэвэрлэх ажилд онцгой анхаарч байгаа бөгөөд халтиргаа гулгаа ихтэй газруудад давс, бодис цацах ажлыг эрчимжүүлээд байгаа юм. Түүнчлэн хороод цас мөс цэвэрлэх их цэвэрлэгээний ажлыг амралтын өдрүүдэд тогтмол зохион байгуулан ажиллаж байна.



## Дөрвөн хүн үл мэдэх шингэнд хордож нас баржээ

Дорнод аймгийн Халх гол суманд өнгөрсөн бямба гарагт "Зөв боломж" компанийн 13 ажилтан үл мэдэгдэх шингэн зүйлийг согтууруулах ундаа гэж уусны улмаас хордож, дөрөв нь нас баржээ. Энэ дагуу Эрүүл мэндийн яамны удирдлагууд тус аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн дарга, эмч мэргэжилтнүүдтэй цахим хурлыг яаралтай хийж, өвчтөнүүдийн биений байдал, тусламж үйлчилгээний явцтай танилцан, мэргэжил арга зүйн зөвлөмж өгчээ. Тэгвэл өчигдрийн байдлаар хордсон хүний тоо 21-д хүрсэн талаар Эрүүл мэндийн яамнаас мэдээлэв. Улмаар өвчтөнүүдэд яаралтай эмчилгээ хийж, таван хүнийг гемодиализын эмчилгээнд оруулсан байна.

Одоогоор зарим өвчтөний биений байдал тогтворжих хандлагатай хэмээн мэдээлсэн юм. Энэ талаар Эрүүл мэндийн яамнаас тодруулахад, "Эрүүл мэндийн яамны удирдлагууд тус аймгийн Бүсийн оношлогоо, эмчилгээний төвийн дарга, эмч мэргэжилтнүүдтэй цахим хурлыг яаралтай хийж, өвчтөнүүдийн биений байдал, тусламж үйлчилгээний явцтай танилцан, мэргэжил арга зүйн зөвлөмж өглөө. Уг цахим хуралд ЭМЯ-ны удирдлагууд болон сэхээн амьдруулах, эрчимт эмчилгээ, хордлого, эмгэг судлалын мэргэшлийн зөвлөх эмч, тандалт судалгааны багийнхан оролцлоо. Хурлын шийдвэрийн дагуу нарийн мэргэжлийн эмч нарын багийг Дорнод аймагт яаралтай ажиллуулахаар томилон явууллаа" гэв.



### ДОРНОГОВЬ АЙМАГ

## Хамтын шийдэл-хөгжлийн гарц бизнес эрхлэгчдийн зөвлөгөөн боллоо

Аймгийн Засаг даргын 2016 оны А/515 тоот захирамжаар "Хамтын шийдэл-Хөгжлийн гарц" сэдэвт бизнес эрхлэгчдийн зөвлөгөөн өнгөрсөн бямба гарагт "Саран хөхөө" театрт боллоо. Уг зөвлөгөөнийг Дорноговь аймаг дахь салбар танхим, Ажил олгогч эздийн холбоо, Баялаг бүтээгчдийг дэмжих холбооны салбар хороотой хамтран зохион байгуулжээ.

Зөвлөгөөнд УИХ-ын гишүүн Б.Дэлгэрсайхан, аймгийн удирдлагууд, ИТХ-ын төлөөлөгчид,

сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга нар болон холбогдох албаны төлөөлөл, жижиг дунд үйлдвэр, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжийн нийт 350 гаруй хүн оролцсон юм. Энэ үеэр тус аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин жижиг дунд үйлдвэр, аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлууд, цаашдын хамтын ажиллагаа, орон нутгаас хувийн хэвшлийг дэмжих бодлогын талаар илтгэл, мэдээлэл хийжээ.

## Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх ёслол боллоо

Монгол Улсын төрийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйл, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1995 оны 109 дүгээр зарлигаар баталсан "Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам"-д заасны дагуу аймгийн төрийн захиргааны албан хаагчдын тангараг өргөх ёслолын ажиллагааг өнгөрсөн бямба Соёмбо цогцолборт зохион байгууллаа. Ёслолын үйл ажиллагаанд аймгийн ИТХ-ын дарга С.Түмэнбаяр,

аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин, АЗДТГ-ын дарга Б.Ганзориг, Сайншанд сумын Засаг дарга С.Одбаяр болон холбогдох албаны төлөөлүүд оролцов. Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх ёслолд аймгийн төрийн захиргааны 41 албан хаагч оролцож, төр, ард түмнийхээ төлөө үнэнч шударга ажиллахаа илэрхийлж, төрийн далбаандаа хүндэтгэл үзүүлэн тангаргийн бичигт гарын үсэг зурсан юм.

### PHOTO NEWS

*Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит шагналыг шилдэг залуу эрдэм шинжилгээний ажилтан, судлаачдад гардууллаа. Энэхүү ШУА-ийн Хими, хилийн технологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор О.Хүрэлдаваа, Анагаах ухааны салбарт шинэ нээлт хийсэн Япон улсын Хирошита их сургуулийн Биоанагаах ба Эрүүл мэндийн шинжлэх ухааны сургуулийн туслах профессор, доктор Б.Булдэлгэр, Монгол хэлний үг бүтээх нийтлэг загварыг боловсруулсан ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор Ж.Ганбаатар нар хүртсэн юм.*



Гэрэл зургийг Г.АРТҮҮЖИН

# NO STRESS

ДУУЛГАХ СОНИН

## “Монгол орон, Монголчууд миний дуранд” УРАЛДААНЫ ШИЛДЭГ 100 БҮТЭЭЛ АНГИЙГ ЗОРИНО

Монгол улс тунхагласны түүхт 92 жилийн ойн баярыг угтан “ЧИНГҮНЖАВ САН”-аас мэргэжлийн гэрэл зурагчид болон гэрэл зураг сонирхогчдын дунд “Монгол орон, Монголчууд миний дуранд” /МММД/ гэрэл зургийн уралдааныг зохион байгуулсан билээ. Гэрэл зургийн бүтээлээр дамжуулан хүүхэд залуучуудад эх орноо хайрлах, улс үндэстнээрээ бахархах хүмүүжил олгох, гадаадын улс орон, зочид төлөөлөгчид, жуулчидад зургийн цомог хэлбэрээр хэвлэн гаргаж эх орноо сурталчилан таниулах нь энэхүү уралдаан зорилго байлаа. Тэгвэл өнгөрсөн баасан гарагт “Монгол орон, Монголчууд миний дуранд” /МММД/ гэрэл зургийн уралдааны шилдэг 100 бүтээлийн үзэсгэлэн “Хүннү Молл”-д байрлах “Гамма” галерейд нээлтээ хийлээ. Энэхүү уралдаанд 400 гаруй гэрэл зурагчдын 1800-гаад бүтээл ирснээс шилдэг 100 гэрэл зургийн эзэн батламжлаа гардаг авсан юм. Эдгээр 100 уран бүтээлчийн гэрэл зураг Англид гарах гэрэл зургийн үзэсгэлэнд тавигдах ажээ.



Гэрэл зургийн ГАРТУУХИНЫ

Улаанбаатарт:

Маргааш  
Өдөр -11  
Шөнө -17

Нөгөөдөр  
Өдөр -13  
Шөнө -19

**Өдрийн зурхай**

ӨВЛИЙН ЭХЭН ШАРАГЧИН ГАХАЙ САР НАЙМАН ЦАГААН МЭНГЭГЭЙ ХӨХ БАР ӨДӨР

Наран ургах шингэх: 08.17-17.03  
Үс засуулбал: Сүлд тэнгэж одно



Тухайн өдөр морь, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус муулах, сан тавиулах, угаал үйлдэх, альчуулах, өглогийн түллэг хийх, хийг дуудуулах, хот балгадын үйл, цэрэг, цагдаагийн үйл, тангарагаа буцаахад сайн. Золиг гаргах, болбын үйл, сэтгэлд сэтэй газар очих, хүүхэд хөлд оруулахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, тогой, хонь, нохой болой. Хол газар яваар одогсод баруун урагш төрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиролжгүй.



**Бидэнд тохиолдсон**

**КҮНДХЭН ХӨГТЭИ ЯВДЛУУД**

**Gegee Ireedu**

Хадам ээж семинартай гэртэй байхгүй үед нь би очиж таарав. Аав будаатай шөл хийчихсэн идээрэй гээд л. Би ч хөлсөө гаргаад идээд байсан. Оюутан байсан юм өө. Тэгсэн аав бараг уйлахаа шахсан шд. Хоол голдоггүй сайн охин гээд. Тэгсэн тэр хийсэн хоолыг нь надаас өөр гэрийнхэн нь тоож идээгүй юм байн лээ.

**ЭЛСЭЛТИЙН ЗАР**

“Зохномж” дээд сургууль 2016-2017 оны хичээлийн жилд дараах мэргэжлүүдээр өдөр, орой, эчнээ, хөрвөх ангид 4 жил, 2.5 жил, 1.5 жилийн бакалаврын ангид нэмэлт элсэлт авна.

1. Телевизийн сэтгүүлч, зураглаач  
2. Кино, драмын жүжигчин  
3. Кино, телевизийн найруулагч  
4. Бага ангийн багш  
5. Сургуулийн өмнөх боловсролын багш  
6. Эрх зүй  
7. Санхүү, банк  
8. Нягтлан бодох бүртгэл, татвар  
9. Гааль, гадаад худалдаа

**Жич:**  
-IX/1 –нээс хойш судалсан хичээлүүдийн нэмэлт цагаар нөхүүлнэ  
-Өнгөрсөн хугацаанд өөр сургуульд судалсан хичээлүүдийн дүнг тооцож үргэлжлүүлэн суралцах боломж олгоно.

Сэтгүүл зүй, Урлаг судлал, Бизнесийн удирдлага ангиудад магистрын элсэлт авна.  
Холбоо барих утас: 70155585, 91111187, 99608440, 80818021

**СОНИРХУУЛАХАД**

### “Монголын үндэсний балет”-ын шилдгүүд тодорлоо

Монгол улсын гавьяат жүжигчин, Монгол улсын Соёлын элч Д.Алтанхуягийн нэрэмжит “Монголын үндэсний балет” улсын анхдугаар уралдааныг энэ сарын 25, 26-нд Монголын хүүхдийн ордонд амжилттай зохион байгууллаа. Анхдугаар уралдаанд төвийн болон орон нутгаас сонгодог бүжгийн урлагт сонирхолтой, мөн хичээллэж буй нийт 128 авьяаслаг хүүхдүүд бүртгүүлж, ур чадвараараа өрсөлдсөн байна. Эдгээрээс хоёрдугаар шатанд 6-8, 9-11, 12-14, 15-18 гэсэн дөрвөн насны ангилалд 38 балетчин тунан үлдэж, шилдгүүдээ тодруулсан юм. Анхдугаар тэмцээний зочин шүүгчээр Монгол Улсын Ардын

жүжигчин, Төрийн шагналт Б.Жамьяндагва гуай оролцсон бөгөөд “Токио Комаки балет” компанийн захирал Со кикучи, Япон улсын “Асами Маки балет” компанийн гоцлол бүжигчин Шао Зи Жун, Соёл урлагийн багш балетмейстер Д.Алтантуяа болон Монгол улсын гавьяат жүжигчин, Монгол улсын Соёлын элч Д.Алтанхуяг нар шүүсэн байна. Тэмцээний хамгийн бяцхан бүжигчид болох 6-8 насны ангилалд Тэргүүн байрыг Монголын Хүүхдийн ордны Хулан багштай бүжигчид авчээ. Харин 15-18 насны эрэгтэй бүжигчдийн төрөлд тэргүүн байрт О.Даваадорж шалгарсан аж.

### “Гоёл-2017” наадмын загварын долоо хоног эхлэв

Монголын загварын ертөнцийнхнийг нэг дор чулуулдаг “Гоёл-2017” наадмын загварын долоо хоног өнгөрсөн бямба гарагт “Blue Sky”-ын “Crystal” танхимд эхэллээ. Монголын дизайнеруудын холбооноос жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Гоёл” наадмын сүүлийн шатны шалгаруулалт ирэх арванхоёрдугаар сарын 1-нд болно. “Гоёл” наадмыг утгаж зохион байгуулдаг загварын долоо хоног хоёр өдөр үргэлжилнэ. Загварын долоо хоногийг “Эвсэл” ХК-ийн дизайнерууд ноолууран пальто, өдөр тутмын хувцасны загвараараа эхлүүллээ. Өнөөдөр Үйлдвэрлэл урлалын сургууль, дизайнер Арнунзааяа, Эрдэнэбаяр, Эрболд, Урангоо, “Үргэлж залуу” Fashion House, “DFD” дизайнер Алтанчимэг, “Precious Fashion House”, дизайнер Отгон нар коллекцио толилуулна. Харин маргааш найман хувцас загварын компани, хоёр дизайнер бүтээлээ дэлгэх нь ээ. Монголын дизайнеруудын холбооноос 29 дэх жилдээ зохион байгуулах гэж буй “Гоёл” наадамд Монголд үйл ажиллагаа явуулж байгаа хувцас загварын агентлаг, салон, үйлдвэрүүдийн нийт 50 гаруй дизайнер “Шилдэг дизайнер”, “Шилдэг загвар”, “Шилдэг зохион бүтээх товчоо” зэрэг номинацад өрсөлдөх юм.

ТӨСӨӨЛЛӨӨС ИЛҮҮГ ТЭНГИСЭЭС...

## ХЯМДРАЛ, УРАМШУУЛАЛ

Даваа Мягмар Ахагва Пүрэв Баасан Бямба Ням

ЭХНИЙ ҮЗВЭР БҮР ХЯДРАЛТАЙ: Том хүн - 5000Т, Хүүхэд - 4000Т

Хосуулын өдөр	Оюутаны өдөр	Ахмадын өдөр
Хосоороо ирсэн хүн бүрт тасалбар <b>5000Т</b>	Өдрийн дурш оюутануудад тасалбар <b>5000Т</b>	10:00-17:00 Цагийн хооронд тасалбар <b>4000Т</b>

### ТӨРСӨН ӨДРИЙН УРАМШУУЛАЛ

Тасалбараа авааг → Уугаа Попкорн → Уусалгаа